- “Монголын мэдээ” Монголын түүхийг бичнэ -

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3.227.168... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2018.09.24. Даваа. №162 (5012) ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ Худалдах үнэ 500 төг

- “Дэлхийн сонины холбоо”-ны гишүүн
- 1999 оны шилдэг чөлөөт хэвлэл
- 2002 оны шилдэг хэвлэл
- 2013 оны Монгол Улсын шилдэг сонин
- Best of Mongolia-2016 - Оны шилдэг сонин

www.dardas.mn
facebook.com/dardas.mn
twitter.com/MMdardas
mongoliinmedeesonin@gmail.com

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР




20 дахь жилдээ

Дугаарыг эрхэлсэн Нэргүйн ПУНЦАГБОЛД

ТОМИЛОЛТ



## ОЙ ШАТААД 16 ХАВАР, ТЭД ТӨРӨӨД 16 НАМАР

–Монгол Улсын Ерөнхийлөгчийн Завхан аймагт ажилласан томилолт–

Гэрэл зургийг Ш.ОТГОНЖАРГАЛ

Үргэлжлэл нь IV нүүрт

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

## Зорчигч тээврийнхэн өвөлд бэлэн



Г.САНЖААХАНД
xandaa1995@gmail.com

*Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-аас “Бид өвөлд бэлэн” өдөрлөгийг өнгөрсөн баасан гарагт “Хараацайн жигүүр” ХХК-ийн байранд зохион байгууллаа. Энэ үеэр манай сонины сурвалжлах баг хамт явж өвөлжилтийн бэлтгэл ажил хангагдсан эсэхийг сурвалжилсан юм.*

Аж ахуйн нэгжүүд өвөлд бэлэн эсэхийг энэхүү өдөрлөгөөс харж болно

Манай сурвалжлах баг 11.00 цаг өнгө-рөөгөөд төв цэвэрлэх байгууламжийн зүүн талд байрлах “Хараацайн жигүүр” ХХК-ийн байранд очсон юм.

Үргэлжлэл нь VI нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

## АРДЫН НАМ ҮНСЭЛТ, ТЭВРЭЛТЭЭС АНГИЖИРЛАА

–Удирдах зөвлөлөөс нэр дэвшсэн Су.Батболд гурван хүний саналаар өрсөлдөгчдөө ялагджээ–





Б.ӨНӨРТОГТОХ
baljirunurtogtokh@gmail.com

Нийслэлийн МАН-ынхан өнгөрөгч баасан гарагт албан ёсны даргатай болов. Нийслэлийн МАН-ын хороог 2016 оны сонгуулийн дараа удирдаж байсан Ц.Сандуй 60 тэрбумын хэрэгт холбогдож, өнгөрөгч есдүгээр сард ажлаа өгснөөр үүрэг гүйцэтгэгч даргатай бүтэн жил болсон байдаг. Энэ хугацаанд их л олон зүйл болжээ. Хэд хэдэн удаа хурлаа зарлах гэж оролдсон ч бүтэлгүйтлээ. Хоорондын зөрчил нь туйлдаа хүрч, “хор найруулах” ажил хийж үзлээ. Өөрөөр хэлбэл, нийслэлийн есөн дүүргийн намын хороо, 152 үүрийн гишүүдээс бүрдүүлэх учиртай 369 квотоос 69-ыг нь “хулгайлж”, дарга нарт зориулж квот бэлтгэх тохироо явсан ч бүтэлгүйтэж байлаа. Энэ мэтээр нэг жилийн хугацаанд хагарч бутарч, харлуулж, муулж зөрчилдсөөр жинхэнэ даргаа сонгожээ, тэд. Зөрчил ингээд дуусчихгүй байх. Учир нь пүрэв гарагт МАН-ын Удирдах зөвлөл хуралдаж, хотын мээр Су.Батболдыг Нийслэлийн МАН-ын даргаар сонгохоор тохироо хийгээд байв. Харин эртнээс энэ албан тушаалд яригдсан ч өрсөлдөнө гэдгээ ил тод зарлаж, өрсөлдөгчөө харлуулах гэж давхихгүй зангараг зааж суусан Д.Сумъяабазарыг 34 дүгээр Бага хурлын үеэр заалнаас нэр дэвшүүлж оруулж ирсэн юм. УИХ-ын гишүүн Б.Энх-Амгалан түүний нэрийг дэвшүүлсэн бөгөөд 359 төлөөлөгчийн санал хураалт баасан гарагийн шөнөөр үргэлжилж, бямба гарагийн үүрээр дүнгээ гаргажээ. Ингэснээр Удирдах зөвлөлийн “урилгатай” Су.Батболд нэг ч хүрэхгүй хувийн саналаар буюу гурван хүний саналаар ялагдал амсав. Дээгүүрээ тохироогоо хийсэн ч хөлөө бэлтгэж чадаагүй, эгэл гишүүдээ үл тоосныхоо горыг хангалттай амслаа. Хотын фракцийн толгойлогч М.Энхболд 1999 оноос хотын даргын суудалд очсоноос хойш үндсэндээ нийслэлийн хувь заяа энэ фракцийн гарт ороод байсан юм. Намаа ч тэд ээлжлэн удирдаж, орны хүнээ томилдог бичигдээгүй хуультай байлаа. Харин 34 дүгээр бага хурлаар хотын фракцийн олон жилийн ноёрхлыг, угсаа залгамжилдаг ураг төрлийн томилгоог тасалж чадлаа. 24 цагаар үргэлжилсэн хурлын хамгийн том үр дүн энэ байв. Нөгөөтэйгүүр, энэ удаагийн хурал илүү ширүүн уур амьсгалтай өрнөжээ. Гаднаа баривчилгаатай, дотроо нанчилдаантай болов.

Үргэлжлэл нь III нүүрт



МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## “Эерэг, аюулгүй, хариуцлагатай цахим орчин” аян эхэлнэ

Х.БОЛОР

”Цахим орчин дахь хэрэглээний соёлыг төлөвшүүлэх үүднээс нийслэлийн Залуучуудын хөгжлийн газар “Эерэг, аюулгүй, хариуцлагатай цахим орчин” аяныг маргааш буюу даваа гарагаас эхлэн долоо хоногийн хугацаатай зохион байгуулж байгаа юм. Аяны хүрээнд хэвлэл мэдээллийн салбарт ажиллах 300 оюутан аяны элч болж, бусдыг эерэг зүйлд уриалах ажээ. Аяны эхний өдөр буюу даваа гарагийг эерэг мэдээлэл түгээх, мягмар гарагийг талархах, лхагва гарагийг бахархах, болгон зарласан байна. Харин баасан гарагийг өөрийгөө хөгжүүлэх, бямба гарагийг хариуцлагатай, ням гарагийг хамгаалалтын өдөр болгон зарлажээ.

## Батлан хамгаалахын сайд Н.Энхболд Уулын явган цэргийн 232 дугаар батальонд зочлов

Х.БОЛОР

Батлан хамгаалахын сайд Н.Энхболдын ХБНГУ-д хийж байгаа албан ёсны айлчлал үргэлжилж байна. Тэрбээр айлчлалын бүрэлдэхүүний хамт ХБНГУ-ын Бавари мужийн Бийшофсвийзен хотноо байрлах Холбооны Зэвсэгт хүчний Уулын явган цэргийн 23 дугаар бригадын 232 дугаар батальонд зочилжээ.

Уулын явган цэргийн 23 дугаар бригадын удирдлага, батальоны бие бүрэлдэхүүн Батлан хамгаалахын сайд Н.Энхболдод, ангийнхаа үүрэг, үйл ажиллагааны онцлогийг танилцуулж, үзүүлэх сургууль сонирхуулсан байна.

Уулын явган цэргийн 232 дугаар батальоны цэргийн алба хаагчид нь Монгол Улсад 2014, 2016 онуудад ирж, Исламын Бүгд Найрамдах Афганистан Улсад явагдаж буй энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн багийн ажиллагааны өмнөх сургалтыг хамтран зохион байгуулж байсан юм.

Айлчлалын сүүлийн өдөр Батлан хамгаалахын сайд Н.Энхболд ХБНГУ-ын Холбооны Канцлерийн Аюулгүй байдал, гадаад бодлогын зөвлөх, Холбооны сайд Ян Хекер, Бундестагийн гишүүн, Бунтестагийн Батлан хамгаалах Байнгын хорооны гишүүн Фритц Фелденьтрой нартай албан ёсны уулзалт хийж, хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны талаар санал солилцсон байна.

ММ-ИЙН ТОДРУУЛГА

# Г.Дашням: Аппликейшнээс дугуйнууд хаана явж байгааг харж болдог



Г.САНЖААХАНД
xandaa1995@gmail.com

*Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Дэлхийн өндөр хөгжилтэй хотуудын жишигт нийцсэн “Түрээсийн дугуйн үйлчилгээ” бий болгох зорилт тавин ажилласны үр дүнд Улаанбаатар хотод “UBIKE” түрээсийн дугуйн үйлчилгээ нэвтэрч, үйлчилгээгээ үзүүлж эхлээд байгаа билээ. Энэ сарын 14-нөөс “UBIKE” төсөл өргөжиж, үйлчилгээ үзүүлэх дугуйн тоогоо нэмсэн юм. Энэ талаар “Никель Ганбаа” ХХК-ийн үүсгэн байгуулагч Г.Дашнямаас тодруулллаа.*

**-“UBIKE” түрээсийн дугуйн үйлчилгээ хэрэгжиж эхэлснээс хойш өнөөдрийг хүртэл хэдэн байршилд, хэчнээн дугуй байршуулаад байна вэ?**

-Өнөөдрийн байдлаар 17 байршилд 170 орчим дугуй байршуулаад байна.

**-Түрээсийн дугуйн байршлууд хаана, хаана байрлаж байгаа вэ?**

-Дугуйн зогсоол баруун дөрвөн замаас эхэлж байгаа. Tedy худалдааны төвийн баруун талд, Тавдугаар сургууль, Хүүхдийн урлан бүтээх төв, Улсын их дэлгүүр, Сүхбаатарын талбай, Жентро, UBH центр, 13 дугаар хороолол, 19-ийн жентро, Zaisan Hill зэрэг байршлуудад байрлаж байгаа.

**-Дугуйгаа зогсоолд нь байршуулаагүй тохиолдолд яах вэ. Заавал зогсоолд нь байршуулах ёстой юу?**

-Мэдээж заавал зогсоолд нь байршуулах ёстой. Зогсоолд нь байршуулаагүй тохиолдолд 2500 төгрөгийн торгууль төлөх юм.

**-Зогсоолгүй газар тавьсан дугуйг хүмүүс унаад цааш явж байна уу. Эсвэл та хэд өөрсдөө зогсоолд нь байршуулж байгаа юу?**

-Ихэнхдээ өөрсдөө л дугуйн зогсоолд аваачиж байршуулдаг.

**-Дугуй түрээсийн үйлчилгээг соёлтой, боловсон хэрэглэсэн, байнгын үйлчлүүлэгчдэдээ урамшуулал олгох үйл ажиллагааг зохион байгуулсан гэсэн. Урамшууллын оноог хэрхэн авах вэ?**

-Унаж явсан дугуйгаа зогсоолд байнга тавьдаг, тогтмол хэрэглэж байгаа 200 хүнд Засаг даргын тамгын газраас 50 цагийн урамшуулал өгсөн. Дугуй түрээсийн үйлчилгээнд хамрагдаж байгаа үйлчлүүлэгчид урамшуулал оноо цуглуулах боломжтой. Яаж гэхээр зогсоолгүй газар үлдээсэн дугуйг унаж зогсоолд байршуулсан тохиолдолд 2000 төгрөгийн урамшуулал авах байгаа.

> ...Унаж явсан дугуйгаа зогсоолд байнга тавьдаг, тогтмол хэрэглэж байгаа 200 хүнд Засаг даргын тамгын газраас 50 цагийн урамшуулал өгсөн. Дугуй түрээсийн үйлчилгээнд хамрагдаж байгаа үйлчлүүлэгчид урамшуулал оноо цуглуулах боломжтой. Яаж гэхээр зогсоолгүй газар үлдээсэн дугуйг унаж зогсоолд байршуулсан тохиолдолд 2000 төгрөгийн урамшуулал авах байгаа...

**-Түрээсийн үйлчилгээ хэрэгжиж эхэлснээс хойш дугуйг хулгайлах, эвдэлж, хэмхлэх, гэр рүүгээ авч явах, хаа хамаагүй газар орхих зэрэг асуудал их гарч байсан. Эдгээр асуудал гарсан хэвээрээ байгаа юу?**

-Нэг хэсэг тийм юм болсон. Одоо дугуй хулгайлах нь харьцангуй багассан. GPS-тэй болохоор хулгайлсан тохиолдолд баригдаж байгаа. Хулгайлагдсан дугуйгаа олоод буцаагаад үйлчилгээндээ ашиглаж байна. “UBIKE Ulaanbaatar” аппликейшнээс дугуйнууд хаана явж байгааг харж болдог. Энэ талаар мэдээлэл багатай хүмүүс дугуй хулгайлаад байх шиг байна. Нисэх, долоон буудал руу авч яваад хашаандаа аваачаад хийчихдэг. Тэгээд баригдсан тохиолдолд цагдаа сэргийлэх болдог.

**-Одоо цаг агаар хүйтэрч, хүйтний улирал эхлэх гэж байна. Тэгэхээр дугуй түрээсийн үйлчилгээ үргэлжлэх боломжтой юу?**

-Хүмүүсээс л шалтгаална. Хүмүүс унаад байх юм бол байж л байна. Унахгүй бол түр завсарлана.

**-Ирэх онд дугуй түрээсийн үйлчилгээ үргэлжлэх байх. Цаашид хэрхэн өргөжүүлэх вэ?**

-Ирэх онд 500 дугуй шинээр хийж, 50 зогсоолд байршуулна гэж төлөвлөсөн байгаа.

PHOTO NEWS



*Гэрэл зургийг Т.САНДАГ-ОЧИР*

*“Автомашингүй өдөр” өнгөрсөн бямба гарагт болов.*

МЭДЭЭЛЭЛ

## Хурандаа С.Хүрэлбаатарыг шалгаагүй

Х.БОЛОР

Энэ есдүгээр сарын 14-нд Авлигатай тэмцэх газар болон Цагдаагийн байгууллагын хамтарсан ажлын хэсгийнхэн Хан-уул дүүргийн Цагдаагийн нэгдүгээр хэлтсийн Мөрдөн байцаах тасгийн дарга, хошууч Г.Алтан-Очирыг хээл хахуулийн хэрэгт холбогдуулан саатуулсан талаар манай сонин мэдээлсэн билээ. Тэрхүү мэдээлэлд түүнтэй хамт тус хэлтсийн дарга, хурандаа С.Хүрэлбаатар, Төмөр замын хэлтсийн дарга, хурандаа Ч.Болдбаатар нарыг шалгаж байгаа талаар дурьдагдсан юм. Тэгвэл албан эх сурвалжийн өгч буй мэдээллээр хурандаа С.Хүрэлбаатар, Ч.Болдбаатар нарыг ямар нэг байдлаар шалгаагүй юм байна. Энэ талаар ЦЕГ-ын Хэвлэл мэдээллийн төвийн дарга, цагдаагийн дэд хурандаа Б.Баатархүү болон АТГ-ын Хэвлэл, олон нийттэй харилцах ажилтан, комиссар Т.Мөнхтунгалагаас тодруулахад, С.Хүрэлбаатарыг шалгаагүй гэсэн мэдээллийг өгсөн юм. Тиймээс тус хэрэгт Хан-уул дүүргийн Цагдаагийн нэгдүгээр хэлтсийн Мөрдөн байцаах тасгийн дарга, хурандаа С.Хүрэлбаатар холбоогүй болохыг ийнхүү эх сурвалжууд мэдээллээ.

МЭДЭЭЛЭЛ

## Боловсролын салбарын бодлогын дүн шинжилгээний чадавхийг бэхжүүлнэ

Г.САНЖААХАНД

Энэ оны хоёрдугаар сард БСШУСЯ, Азийн хөгжлийн банк болон Сангийн яам “Боловсролын салбарын хөгжлийн Мастер төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүлэх” төслийн санамж бичигт гарын үсэг зурсан билээ. Уг санамж бичгийн хүрээнд Монгол Улсын боловсролын салбарын хөгжлийн мастер төлөвлөгөө боловсруулах ажлыг БСШУСЯ, Азийн хөгжлийн банкны техникийн туслалцааны төслийн багтай хамтран хэрэгжүүлж байгаа аж. Шинэ мастер төлөвлөгөөг боловсруулж, салбарын болон дэд салбарын судалгаанд нарийвчилсан үнэлгээ хийж, үндэсний чадавхийг бэхжүүлэх зорилготой тав хоногийн сургалт семинар энэ сарын 20-нд эхэлсэн юм. Тодруулбал, БСШУСЯ, НҮБ, Азийн хөгжлийн банк хамтран дээрх сургалтыг зохион байгуулж байгаа юм. Сургалтад боловсролын салбарын хөгжлийн мастер төлөвлөгөө боловсруулах ерөнхий болон дэд ажлын хэсгийн гишүүд болох БСШУСЯ болон харьяа байгууллагын удирдлага, мэргэжилтнүүд, их дээд сургуулийн төлөөлөл оролцож байгаа аж. Энэ сарын 25 хүртэл үргэлжлэх сургалтаар төлөвлөлтийн үйл явц, салбарын дүн шинжилгээ болон нөхцөл байдлын дүн шинжилгээ, хүртээмж, дотоод үр ашиг, тэгш боломж, боловсролын чанар, өртөг зардал, санхүүжилт зэрэг сэдвүүд багтжээ. Мөн гадаад үр ашиг , боловсролын салбарын удирдлагын асуудал, боловсролын симуляцийн загвар гэх мэт чухал сэдвүүд ч багтсан байна. Энэхүү сургалт нь дээрх сэдвүүдийн хүрээнд ярилцаж, шийдэл гарган, оролцогчид багаар ажиллаж, дадлага ажил хийж буйгаараа онцлогтой юм.

НИЙГЭМД ЦӨӨН МӨРӨӨР

- Он гарсаар насанд хүрээгүй 174 эрүүлжүүлэгдсэн учраас эцэг, эхчүүдийг хүүхдэдээ тавих хараа, хяналтаа сайжруулахыг цагдаагийн байгууллагаас анхааруулалаа. Эдгээр эрүүлжүүлэгдсэн оюутан, сурагчдын талаарх мэдээллийг сурдаг сургуульд нь албан тоотоор хүргүүлж эхэлсэн тухай НЦГ-аас мэдээлэв.
- Бямба гарагт эхэлсэн Уран хатгамалчдын улсын уралдааны долоон төрөлд тэргүүн байр эзэлсэн хүн тус бүрд Монгол Улсын уран хатгамалч цол олгохоор болжээ.

ЕРӨНХИЙ ЭРХЛЭГЧ: Б.ОЮУНГЭРЭЛ

ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА: Н.ПУНЦАГБОЛД 88096454

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСАГ, ГАДААД МЭДЭЭЛЛИЙН АЛБА: Б.ПҮРЭВЖАВ 99210031

НИЙГЭМ, ЭРЭН СУРВАЛЖЛАХ, ШУУРХАЙ МЭДЭЭЛЛИЙН АЛБА: С.БУДРАГЧАА 90005522

ЦАХИМ ҮЙЛДВЭРЛЭЛ, САНХҮҮГИЙН АЛБА: Э.САЙНЗАЯА 99197866

МЕНЕЖЕРҮҮД: М.ДАВААДУЛАМ 99042510

ФЭЙСБҮҮК: www.facebook.com/mmdardas/

ТВИТТЕР: www.twitter.com/mmdardas

*Улсын бүртгэлийн дугаар: 907300528*
*Индекс: 100757*

Редакцийн хаяг:
Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг.
Чөлөөт хэвлэл сан
/Хэвлэлийн хүрээлэн/.
2 давхар. 209, 210, 211 тоот

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж,
“Чөлөөт хэвлэл сан”-гийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.



...Аалзны тор шиг сүлжсэн фракцийн хүчийг аажим, аажмаар сулруулж чадаж байна. Үүнээс илүү шинэчлэл гэж юу байх билээ. Нам нь шинэчлэгдэж, дотооддоо эрс шинэчлэл хийх нь ээ гэсэн итгэл ч 34 дүгээр хурлын үеэр олон гишүүдэд нь төрсөн биз ээ...

# АРДЫН НАМ ҮНСЭЛТ, ТЭВРЭЛТЭЭС АНГИЖИРЛАА

**–Удирдах зөвлөлөөс нэр дэвшсэн Су.Батболд гурван хүний саналаар өрсөлдөгчдөө ялагджээ–**

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Нийслэл хотод 60 тэрбумын схемийг цэцэглүүлсэн хотын фракцийг эсэргүүцэж, үзэл бодлоо илэрхийлсэн Х.Бат-Ялалт нарын иргэдийг 100 гаруй цагдаагийн хүчээр хүчээр тарааж, баривчилгаа хийх гэж оролдлоо. Ардчилсан Монгол Улсад иргэн хүн үгээ хэлж, үзэл бодлоо илэрхийлэх боломжгүй болсныг энэ үйл явдал нотлох шиг. Мөн мандатын маргаан ч цөөнгүй гарч, хуралд мандатгүй орж ирсэн төлөөлөгчдийг албадан гаргаж, хурлыг удирдаж байсан Нийслэлийн МАН-ын дарга асан Г.Мөнхбаяр багагүй эсэргүүцэлтэй тулгарч, жирийн гишүүд нь "шударга бай, шударга бай" хэмээн орилолдож байлаа. Нөгөөтэйгүүр, "Ноцтой мэдээ" сонины тусгай дугаарыг 369 төлөөлөгчид тараах гэж оролдсон тус сонины Ерөнхий эрхлэгч Б.Галсансүхийг баривчлав. Тус сонины тэргүүн нүүрэнд "60 тэрбумын схемийн "Загалмайлсан эцэг" Ц.Сандуй гэж хэн бэ", "Хятад ламд мөргөж буй хурлын дарга хөөрхий" зэрэг нийтлэл хэвлэгдсэн нь төлөөлөгчдийн үзэл бодолд нөлөөлөх гэсэн, намын гишүүдийн нэр хүндэд халдсан гүтгэлгийн шинжтэй гэж үзсэн учраас эрхлэгчийг нь баривчилж, сонинг тараалгаагүй юм. Удирдах зөвлөлөөс санал авч орж ирсэн Су.Батболд 152 үүрийн дарга нартаа байр амлажээ, түүнийг дэмжигчид хурлаа орхин гарлаа гэх мэтээр 90 гаруй жилийн түүхэнд нь болж байгаагүй үймээн, шуугиантай хурал болох нь тэр. МАН ингэтлээ зөрчилдөж, дотоод ардчилалтай болно гэж хэн санах билээ. Хайрцагласан бодлогоор хурлаа хийж, нижигнэсэн алга ташилт, нялуурсан үнсэлт, тавилттай жүжиглэлтээр хурлаа хийдэг эрх баригч нам энэ удаад сөрөг хүчин шигээ дотоод ардчиллаа харуулав. Ардын нам одоо л үнсэлт, тэврэлтээс ангижирлаа. Цаашдаа ийм хурал тун цөөхнийг харах биз. Нэг талаас харвал МАН хагарч бутарснаа бүх талаар харуулчихлаа гэж дүгнэж болно. Нөгөө талаас харвал МАН шинэчлэгдэж байгаа юм байна. Т.Бадамжунай, М.Энхболд, Н.Багабанди тэргүүтэй цөөхөн хэдхэн улстөрчдийн гарт олон жил "тийчилсэн", дотроо тэмцэлдсэн ч гаргаж чадахгүй явж байсан залуус одоо л тэсэрч эхлэв. Нэгдэж, тэмцэж чадвал хотын фракцийн хязгааргүй ноёрхолд цэг тавьж чадна гэдгээ мэдэрч эхэлжээ. Төв намын даргын томилгоонд залуус эхний ялалтаа авсан. Одоо Нийслэлийн МАН-ыг гартаа оруулж хоёр дахь том ялалтаа авлаа. Аалзны тор шиг сүлжсэн фракцийн хүчийг аажим, аажмаар сулруулж чадаж байна. Үүнээс илүү шинэчлэл гэж юу байх билээ. Нам нь шинэчлэгдэж, дотооддоо эрс шинэчлэл хийх нь ээ гэсэн итгэл ч 34 дүгээр хурлын үеэр олон гишүүдэд нь төрсөн биз ээ. Ардчилсан нам л дотроо тэмцэлдэж, хурал дээрээ зодолдож, хэвлэл мэдээллээр нэгнээ гүтгэж доромжилдог байсансан. Энэ нь АН-ыг илүү амьд байлгадаг, бас илүү хөдөлгөөнтэй болгодог. Харин 90 гаруй жил төрийн эрхэнд суухдаа тоотой хэдхэн улстөрчийг товойлгож, цөөхөн хэдхэн фракцийн хязгааргүй эрх мэдэлд хүргэж байсан МАН нам шиг нам болох гэж ийнхүү зүтгэж байна. Энэ тэмцэл нь буруугаар битгий эргээсэй. Намаа шинэчилж, бугшсан идээ бээрээ шахаасай гэх хүлээлт, хүсэлт мянга мянган жирийн гишүүдэд нь байгаа нь тодорхой. Нийслэлийн МАН нь энэ хурлаар бүрэн утгаараа шинэчлэгдлээ. Тодруулбал, орон тооны нэг, орон тооны бус зургаан дэд даргатай байхаар тогтжээ. Нийслэлийн МАН-ын дэд даргаар Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын орлогч Н.Алтаншагай, харин орон тооны бус дэд даргаар Б.Мөнхбаатар, О.Одбаяр, Ж.Батбаясгалан, Г.Төмөрбаатар, УИХ-ын гишүүн Н.Учрал, Х.Нямбаатар нарын нэрийг дэвшүүлж, баталсан байна. Эдгээр залуус дандаа шинэчлэл, өөрчлөлт хүсч байсан. Харин нийслэлийн МАН-ын хорооны тэргүүлэгчээр намын дүрмийн дагуу намын хорооны дарга, дэд дарга, НИТХ-ын дарга С.Амарсайхан, Хотын дарга С.Батболд, НАМЗХ, НАЭХ, Ахмадын холбооны дарга нар, Баянгол дүүргийн намын хорооны дарга, УИХ-ын гишүүн Ж.Ганбаатар, Сүхбаатар дүүргийн намын хорооны дарга, Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар, Чингэлтэй дүүргийн намын хорооны дарга, УИХ-ын гишүүн Д.Ганболд, Сонгинохайрхан дүүргээс НИТХ-ын төлөөлөгч М.Мөнхжаргал Баянзүрх дүүргийн Засаг дарга Э.Бат-Амгалан, Багахангай дүүргийн ИТХ-ын хурлын дарга Б.Батнасан, Налайх дүүргийн төлөөлөгч Б.Сэмжидмаа нарыг тэргүүлэгчээр томилжээ.




ХААН БАНК САН

ШУГТЭ
УЛСЫН 3 ДУГААР ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

ЦУСНЫ ДАРАЛТ ИХСЭЛТИЙН ЭСРЭГ АЯН-2018

## АРХАНГАЙ, БАЯНХОНГОР АЙМАГТ "ЦУСНЫ ДАРАЛТ ИХСЭЛТИЙН ЭСРЭГ АЯН" ҮРГЭЛЖИЛЛЭЭ









Зүрх судасны өвчний нас баралтын тоон үзүүлэлтээрээ манай улс дэлхийд дээгүүрт ордог. Монголчуудын нас баралтын тэргүүлэх шалтгаанд зүрх судасны өвчин (37%), хоёрдугаарт хавдар (21%), гуравдугаарт осол гэмтэл (13%) орж байна. Иймээс хувь хүн бүр эрүүл мэнддээ хяналт тавих боломжтойг иргэд олон нийтэд ойлгуулж, мэдээлэл зөвлөмж хүргэх зорилгоор ХААН Банкны нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгч ХААН Банк Сангийн хамт олон уг аяныг санаачлагч П.Н.Шастины нэрэмжит Улсын III төв эмнэлэг, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн эмч мэргэжилтнүүд хамтран "Цусны даралт ихсэлтийн эсрэг аян"-ыг хоёр дахь жилдээ амжилттай зохион байгуулж байна.

Энэхүү арга хэмжээний хүрээнд өнгөрсөн жил Улаанбаатар хотын хэмжээнд "Цусны даралт ихсэлтийн эсрэг аян"-ыг хэрэгжүүлсэн бол өнөө жил зүрх судасны өвчлөл өндөртэйд тооцогддог аймгууд руу үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллахаар болсон юм. Энэ ч үүднээсээ 2018 оны долдугаар сард орон нутаг дахь аяны нээлтийг Булган, Хөвсгөл аймагт зохион байгуулж, нийтдээ 2168 иргэн (эрэгтэй 38.5%, эмэгтэй 61.5%)-д цусны даралт ихсэх өвчний эрт илрүүлэг үзлэг хийж, 280 иргэнд цусны даралт ихсэх өвчин, түүний эрсдэлт хүчин зүйлийн талаарх эрүүл мэндийн боловсрол олгох сургалт явуулж, 578 иргэнийг зүрх судас, зүрхний шигдээс, мэдрэл, тархины харвалт, бөөр, хоол боловсруулах замын эмгэгийн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулсан билээ.

Тэгвэл "Цусны даралт ихсэлтийн эсрэг аян" орон нутагт үргэлжилж, 9-р сарын 17-19-нд Архангай, 9-р сарын 20-22-нд Баянхонгор аймагт амжилттай зохион байгууллаа.

Архангай аймагт зохион байгуулсан аяны хүрээнд нийт 1,508 иргэнийг үзлэг оношилгоонд үнэ төлбөргүй хамруулж, эрсдэлт бүлгийн буюу цусны даралт ихсэх өвчтэй, зүрх судасны өвчин илэрсэн 245 иргэнд УГТЭ-ийн нарийн мэргэжлийн эмч нар үзлэг хийн зөвлөгөө мэдээлэл хүргэж ажилласан байна. Мөн Архангай аймгийн ерөнхий боловсролын сургуулийн 180 орчим сурагчид "Эрүүл мэндийн боловсрол гэж юу вэ?" сэдэвт сургалт зохион байгуулсан юм.

Аяны хүрээнд орон нутгийн эмч, мэргэжилтнүүдийг чадавхижуулах сургалт зохион байгуулсан төдийгүй цусны даралт ихсэлтийг эрт илрүүлэх, оношлох, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хүн амын дундах даралт ихсэлтийн шалтгаан, нөхцөлийн судалгаа хийх зэрэг зорилтот үйл ажиллагаа хэрэгжүүлжээ. Мөн эрүүл мэндийн илрүүлэг үзлэгийг Улсын III төв эмнэлгийн эмч нар аймгийн нэгдсэн эмнэлгийн эмч, мэргэжилтнүүдийн хамт хийж, нээлттэй өдөрлөгт хүрэлцэн ирсэн иргэдийн цусны даралтыг хэмжиж, биеийн жингийн индексийг тодорхойлсон юм. Түүнчлэн орон нутгийн иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, цусны даралт ихсэлтэд хүргэдэг эрсдэлт хүчин зүйлс болон түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх тухай зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан байна. Тус аяны хүрээнд хийгдсэн бас нэгэн томоохон ажил бол Архангай аймгийн ХААН Банкны салбарт цусны даралт хэмжих багаж бүхий эрүүл мэндийн булан байгуулсан явдал юм. Энэхүү эрүүл мэндийн булан ажиллаж эхэлснээр иргэд банкаар үйлчлүүлэх үедээ цусны даралтаа хэмжиж, тогтмол хянаж байх боломжийг бүрдүүлж өгсөн юм.

Статистик тоон судалгаагаар Баянхонгор аймагт 2017 онд хэвтэн эмчлүүлсэн 10 мянган хүн тутмын 176,5 нь цусны даралт ихсэлттэй гэсэн дүн гарчээ. Өөрөөр хэлбэл, 100 хүн тутмын хоёр нь цусны даралт ихсэх өвчтэй гэсэн үг бөгөөд энэ нь маш их анхаарал татах үзүүлэлт болохыг эмч нар хэлж байна. Баянхонгор аймгийн 73 эмч сувилагч нарт эхний өдөр буюу 9-р сарын 19-нд сургалт зохион байгуулсан бол хоёр дахь өдөр аймгийн Хөгжимт драмын театрт тус аяны нээлтийг хийж, энэ үеэр 1,400 иргэний цусны даралтыг хэмжиж, эрүүл мэндийн илрүүлэг үзлэг хийж, 192 иргэнийг УГТЭ-ийн нарийн мэргэжлийн эмч нар нарийвчилсан үзлэг оношилгоонд оруулж, зөвлөгөө мэдээлэл өгчээ. Цусны даралт ихсэх өвчин бусад олон өвчний суурь болдгийг хүмүүс тэр бүр мэддэггүй. Өөрөөр хэлбэл, зүрхний дутагдалд орох, тархинд цус харвах, зүрхний шигдээс болох магадлал өндөр ажээ.

Түүнчлэн энэ өвчин эрс залуужиж, хот суурин газрын төдийгүй орон нутгийн хүн амын дунд өвчлөл хурдтай нэмэгдэж буй нь удаан хугацаагаар суугаа ажил эрхлэх, хөдөлгөөний хомсдол, хүн амын дундах таргалалт, зохисгүй хооллолт, амьдралын хэв маяг өөрчлөгдсөн, стресс зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж буй тухай эмч мэргэжилтнүүд хэлж байгаа билээ.

Аяны тухай мэдээллийг ард иргэдэд урьдчилан түгээх, эрсдэлт бүлгийн иргэдийг урьдчилан бэлтгэх ажилд дээрх аймгуудын Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн газар болон ХААН Банкны тухайн орон нутгийн салбарын ажилтнууд идэвхтэй оролцож, бэлтгэл ажлыг сайтар бэлтгэж ажилласныг онцлон дурдах хэрэгтэй болов уу.

Мөн аймгийн ЗДТГ-ын удирдлагууд бүх талаар дэмжиж, ард иргэдээ идэвхтэй хамрагдахыг уриалж, цаг үеэ олсон чухал ач холбогдолтой ажил өрнүүлж буйд талархал илэрхийлж байлаа. Иргэд, олон нийтийг цусны даралт ихсэх өвчин, түүний эрсдэлт хүчин зүйлс, хүндрэлээс урьдчилан сэргийлэх мэдлэг, дадалд сургаснаар хүн амын өвчлөл, нас баралтын гол шалтгааныг бууруулах боломжтой юм.

Өвдсөнийхөө дараа биш өвдөхөөсөө өмнө урьдчилан сэргийлж чаддаг эрүүл, хариуцлагатай иргэн байхын тулд та бүхэн урьдчилан сэргийлэх үзлэгт тогтмол хамрагдаж хэвших нь өөрийгөө болон гэр бүл, хайртай дотны хүмүүсээ хамгаалж чадах чухал алхам юм.

**2018 онд орон нутагт**

| | БУЛГАН | ХӨВСГӨЛ | АРХАНГАЙ | БАЯНХОНГОР | НИЙТ ДҮН |
|---|---|---|---|---|---|
| Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан иргэдийн тоо | 1100 | 1000 | 1500 | 1400 | 5000 |
| Нарийн мэргэжлийн үзлэгт хамрагдсан эрсдэлт бүлгийн иргэдийн тоо | 250 | 220 | 245 | 192 | 907 |
| Сургалтад хамрагдсан орон нутгийн эмч мэргэжилтнүүдийн тоо | 60 | 60 | 79 | 73 | 272 |
| Даралтын аппарат бүхий эрүүл мэндийн булан | - | 1 | 1 | - | 2 |
| Нийт явсан км | 636 | 1342 | 906 | 1260 | 4144 |

ТОМИЛОЛТ

# ОЙ ШАТААД ТЭД ТӨРӨӨД

–Монгол Улсын Ерөнхийлөгчийн За





Б.БУНДХОРОЛ

batbund@gmail.com

## Томчууд ойг шатаасан, бид цэвэрлэж байна

2018 оны есдүгээр сарын 18-ны өдөр. Солонготын даваа даван бэлийг нь дагаад уруудахад үржил шимгүй, унанги болсон ой, хаа нэгтэй түлэгдэж хорчийсон модод ёрдойж, сэрвийн үргэлжилнэ. Хэдийгээр ойн зах хөвөөгөөр залуу модод ногоорох авч өнөөх үржил шимгүй болсон моддын дэргэд хэмжээгээр жижиг, талбайгаар бага газрыг эзлэх аж. Завхан аймгийн хэмжээнд 732 мянган га ойтой буюу манай улсын нийт ойн сангийн дөрвөн хувь нь байдаг билээ. Энэ аймагт 2000-аад оны эхээр жил дараалан гарсан их түймрээр 133 мянган га ойгоо буюу ойн сангийнхаа 18 хувийг алджээ. Бидний өгүүлэн буй Их уул сумын нутаг болох Солонготын давааны ар бэлд байх Ар ганга хэмээх газар гэхэд нийт ойн сангийн 22 хувийг нь тэр жилийн их түймэрт алдсаны улмаас дээр өгүүлсэн адил харагдаж буй нь энэ. Энэ газар цэрэг эрээн хувцас өмссөн 2000 гаруй хүн ойн цэвэрлэгээ хийх агаад, тэднээс 1600-гаад нь Завхан аймгийн сум бүрээс ирсэн 11, 12 дугаар ангийн сурагчид гэнэ. Харин бусад нь сум бүрээс хүүхдүүдээ хариуцаж ирсэн албаны хүмүүс, мөн мэргэжлийн сургалтад хамрагдсан 400-гаад хөрөөчид, нутгийн иргэд, мэргэжлийн байгууллагынхан ажиллаж буй аж. Энд бүгд ижилхэн цэрэг эрээн хувцас, далбагар нарны малгай өмссөн тул хэнийг нь ч хэн гэж нэгнээс нь ялгах аргагүй аж. Тэдний дунд бусадтайгаа нэгэн адил унанги мод цэвэрлэн явах хүү бол Завхан аймгийн математик, гадаад хэлний гүнзгийрүүлсэн сургалттай Жавхлан цогцолбор сургуулийн 12б ангийн сурагч Ш.Мөнхцоож юм. Тэрбээр "Анх наашаа ирж байгаад шатсан ойг харахад их сэтгэл гонсгор байсан. Биднийг төрж байх үед шатсан нутгийнхаа ойг энэ арга хэмжээний хүрээнд найз, нөхдийнхөө хамт бүгдийг нь биш ч цэвэрлэж байна. Энд ой цэвэрлээд төрсөн бодол бол хүний буруутай үйл ажиллагаанаас ой шатдаг юм байна. Тиймээс хамгийн наад зах нь л гэхэд хогоо хээр гадаа хаяхгүй, хогийн саванд хийж хэвшмээр санагдлаа. Энэ ажилд гар бие оролцож байгаадаа баяртай байна" хэмээн хөө, тортог болсон цагаан бээлийгээрээ нүүрээ шувтран арчаад, инээн хэллээ. Өөрийгөө ЕБС-ийн ангиар биш эл хөтөлбөрт хамрагдаж буй нэршлээрээ буюу хоёрдугаар салааны гуравдугаар тасгийн суралцагч Д. Олзчимэг хэмээн танилцуулсан охин "Түймрийн улмаас бохирдсон ой учир зулзаган моднууд ургаж чадахгүй байсан байна. Унанги болон шатсан модыг цэвэрлэж, зулзаган модыг ургуулах боломжийг гаргах зорилготой ажиллаж байна. Энэ ажиллагаанд оролцоход хамтын хүч, эв нэгдэл гэдэг зүйл ямар их чухал болохыг мэдлээ. Энд анги, тасгийнхаа нөхөд бусад бие бүрэлдэхүүнтэй оролцож байгаадаа баяртай байна" гэсэн юм. "Чандмань-Эрдэнэ" сургуулийн 12а ангийн сурагч н.Ариунзаяа "Томчууд энэ ойг үнэхээр аймшигтай болгосон байгааг хараад харамсч байна. Харин бид өөрийн гараар ойг цэвэрлэж байгаадаа бахархаж байгаа. Мод их унаснаас болж маш олон зулзаган модод далий ургаж байгаа нь харамсалтай харагдаж байлаа. Харин бид унасан моддыг авч, зулзаган моддыг өндөр ургах боломжтой болгож байна. Нуулгүй хэлэхэд энэ ой үнэхээр өрөвдөлтэй, маш их тортогтой байна. Бид гар бие оролцсон учраас хэдэн жилийн дараа өндөр мододтой ой болох байх гэдэгт итгэлтэй байна. Олуулаа хамтарч ажиллаж байгаа учраас ядрахгүй, санаа нийлж хамтран ажиллаж, найз нөхөдтэй болж байна" гэж хэллээ. Мөн тус сургуулийн нэгэн сурагч "Анх аянд оролцохдоо сэтгэл дундуур байсан. Танихгүй олон хүүхэд байх учраас оролцох эсэхдээ эргэлзэж байсан. Харин одоо би баг, хамт олноороо ажиллах, олон янзын үйл ажиллагаанд оролцох зэргээр олон зүйл сурч" гэсэн юм. Ийнхүү эцэг, эхийн гараас салаагүй, ахлах ангийн хүүхдүүд энд хоёр хоног ажиллахдаа 168 га талбайг цэвэрлэсэн гэнэ. Энд харьцуулаад нэмээд хэлэхэд өмнөх жилүүдэд дөнгөн данган 160 га талбайг л цэвэрлэж, амжсан гэж албаны хүн хэлсэн юм. Гэтэл энэ 1600 хүүхэд, мэргэжлийн 66 аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын 400 гаруй ажилтан, албан хаагч, нийт 2200 гаруй хүн хэдхэн хоногийн хугацаанд өмнөх долоон жилийн цэвэрлэсэн ойгоос илүү ойг цэвэрлэжээ. Мөн ойн цэвэрлэгээ хийхийн тулд Тосонцэнгэл сумын Мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төвд 200 хүнд хөрөөчний мэдлэг олгож, сургалтад суулгасныг давхар дурдах хэрэгтэй болов уу. Ийнхүү ойн цэвэрлэж буй байдалтай Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга танилцсан бөгөөд тэрбээр "Нутаг орныхоо шатсан ойг үе тэнгийнхэнтэйгээ нийлэн цэвэрлэж байгаа та бүхнээр бахархаж байна" хэмээн оролцогчидтой уулзахдаа урам өгч байсан юм.







## Бид Чингисийн үр сад

Ерөнхийлөгч Х.Баттулга Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр ч тэр, Ерөнхийлөгч болсноосоо хойш ч тэр, орон даяар явж, иргэдтэй уулзахдаа ярьдаг зүйлийн нэг бол цэрэг эх оронч хүмүүжлийн талаар хөнддөг. Зарим нэгэн хүмүүс "эр, эмгүй цэрэгт татаад хэнтэйгээ байлдах гэж байгаа юм" гэж егөөдөх нь байдаг билээ. Харин өөрөө тайлбарлахдаа "Бид байлдаж дайтах гээд байгаа юм биш. Өнөөдрийн энэ ороо, бусгаа нийгэмд, монгол хүний мөн чанар алдагдаж буй энэ үед, нэгдүгээрт цэрэг эх орон ч хүмүүжил олгосноор залуусын маань бие бялдрын хувьд өв тэгш болно. Хоёрдугаарт сэтгэл зүйн хувьд хувиа бодсон, довоо шарлуулсан хүмүүс биш. Эх орон, ард түмнээ гэсэн хүмүүс бэлдэхэд хэрэгтэй. Гуравдугаарт, цэрэг гэдэг их хүчийг ашиглаад эх орны бүтээн байгуулалтад гар бие оролцуулах, цэрэг болсноор гадны улсын хямдхан ажиллах хүч биш дотооддоо түүнтэй дүйцэх цалин авч ажиллах боломжоор хангах зорилготой" хэмээн тайлбарладаг. Энэ л санааныхаа үндсэн дээр ийм арга хэмжээ зохион байгуулбал хэмээн санал гаргаж байсан аж. Харин уг санааг ажил хэрэг болгосон хүмүүс бол УИХ-ын дэд дарга Я.Санжмятав, Завхан аймгийн Засаг дарга Д.Батсайхан нар юм. Хуучин Завхан аймгийн засаг дарга байсан Я.Санжмятав гишүүн санаачлан, Завхан аймгийн одоогийн удирдлагууд дэмжиж, ажил хэрэг болгосноор "Бид Чингисийн үр сад, Зөв тэмүүлэл-эх оронч манлайлал" сургалт хэрэгжиж эхэлжээ. Энэ сургалтыг хэрэгжүүлэхийн тулд Завхан аймгийн Засаг дарга Д.Батсайхан 2018 оны наймдугаар сарын 02-ны өдөр захирамж гарган эхэлжээ. Тус захирамжийн хүрээнд Завхан аймгийн хэмжээнд 11, 12 дугаар ангийн сурагчдыг бүс бүсээр нь хуваан эхний долоо хоног танхимын хичээл оржээ. Тухайлбал, Хууль сахиулахын их сургуулийн мэргэжлийн багш нар хөтөлбөрийг нь бэлтгэж орсон хичээлүүд болох "Сэтгэлзүйн бэлтгэл", "Амьд гарах ухаан", "Галын бэлтгэл", "Цэргийн дүрэм, жагсаалын бэлтгэл", "Цэрэг эх оронч хүмүүжил", "Биеийн тамир, гардан тулаан" зэрэг зургаан хичээлийн орсон аж. Үүний дараагийн долоо хоногт хээрийн сургалтын төв байгуулан цэрэгжилтийн хэлбэрээр байрлуулан сурсан онолоо практикт буулгасан байна. Тухайлбал, Тосонцэнгэлээс Улиастайн чиглэлд тавьж буй замын чулуу түүлгэх, дээр дурдсан ой цэвэрлэх зэрэг ажилд дайчилжээ. Цэрэг ногоон майханд байрлуулж, цэргийн нормын хоолоор хооллож, өглөө бүрээн дуунаар босгож төрийн далбаагаа мандуулж, оройн тоо хийнэ. Завхан аймгийн Засаг дарга Д.Батсайхан "Аав, ээжийнхээ өврөөс гараагүй олон хүүхдүүдийг нэгэн дор эрүүл, аюулгүй байлгана гэдэг мэдээж хүнд ажил. Тиймээс бид хүний бяцхан үрсийг яаж хүлээж авсан шигээ эрүүл энх, бүрэн бүтэн хүлээлгэж өгөх ёстой. Аймгийн төрийн бүх байгууллагуудын төлөөлөгчид энд ажиллаж байгаа. Эмнэлэг, сургууль, цагдаа, онцгой, Хүүхэд, гэр бүл хөгжлийн газар гээд бүхий л газрууд холбогдох чиглэлээрээ энэ сургалтад хамрагдсан. Мөн сумдын засаг даргын тамгын газрынхнаас эхлээд Хууль сахиулахын их сургууль, Хилийн цэргийн дээд сургууль гээд мэргэжлийн байгууллагууд оролцож энэ бүх үйл ажиллагааг төлөвлөсний дагуу зохион байгуулж байна" хэмээн өгүүлж байсан юм. "Зарим хүмүүс шилжилтийн насны баахан хүүхдийг эцэг, эхээс нь тусгаарлаад л энд толгой түрүүг нь алдуулж байгаа гэж буруугаар ярих ч тохиолдол байна. Гэтэл энд та бүхний харж байгаачлан эрэгтэй, эмэгтэйгээрээ тусад нь байрлуулж байна. Салаа бүрийг Хууль сахиулахын их сургуулийн 3, 4 курсийн ах эгч нар нь хариуцаж байгаа. Эмэгтэй сурагчдын эмэгтэй оюутнууд, эрэгтэй сурагчдыг эрэгтэй оюутнууд, тэдний дээр анги даасан багш нар нь мөн харгалзаж байж энэ хөтөлбөр амжилттай хэрэгжиж байна" хэмээн өгүүлсэн юм. Нээрээ ч энд бүх зүйл нь эмх цэгцтэй аж. Нийт байрлаж

> …Хууль сахиулахын
> сонсогчид ёсолгоо хий
> сурагчид баяртай" хэм
> тойрон одлоо. Цэн
> жагсаалаараа зогсох
> нулимсаа арчин, бие
> нь өхөөрдөм аж. Тэр
> зарим нь өхөөрдөж, за
> арчиж, зарим нь алг
> илэрхийл

буй хээрийн талбайг гурван хэсэгт хуваажээ. Хамгийн хойно байрлах бүст арав гаруй тооны гэр байх агаад эл хэсэгт удирдлагын хүмүүс байрладаг аж. Түүний урьд бүст 50 гаруй гэр барьсан байх агаад зохион байгуулалтын хэсэг буюу сум бүрээс ирсэн холбогдох албаны хүмүүс байрладаг байна. Харин хамгийн урд бүст цэргийн ногоон майхнууд жигдлэн барьсан байна. Энд л 1600 хүүхэд байрладаг аж. Мэдээж эмнэлэг, онцгой, цагдаа гээд тусгайлан бэлдсэн гэрүүд, машин техникүүд бэлэн байдалд байх аж. Мөн нийтийн гал тогоо, угаалгын газар, жорлон, тэр бүү хэл хог хаях цэг нь хүртэл тусдаа байна. Цагдаа, цэргийнхэн 24 цагаар харуул хамгаалалттай байхаар бэлтгэжээ. Манай сурвалжлах баг энд байх хугацаанд оройн хоол болон өглөөний цайны цагаар таарсан юм. Оройн хоолны үеэр охидыг хооллож байхад таарлаа. Нэг ширээг тусгайлан бэлтгэсэн байх агаад энэ ширээ бусад ширээгээ бодвол чихэр, жимс, ундаа, бялуу зэргийг тусгайлан бэлтгэжээ. Энд харин тухайн өдөр төрсөн хүүхдүүд суудаг байна. Өнөөдөр л гэхэд зургаан хүүхдийн төрсөн өдөр болж байгаа гэнэ. Төрсөн өдөр нь тохиож буй хүүхдүүдэд зориулж сургалтад хамрагдаж буй хүүхдүүд нийлээд төрсөн





# 16 ХАВАР, НАМАР

авхан аймагт ажилласан томилолт–

өдрийн дуу дуулж өгч байсан юм. Магадгүй энэ л төрсөн өдөр тэдгээр төрсөн өдрийн эздийн хувьд хэзээ ч мартагдахгүй бизээ. Мөн манай сурвалжлах багийнхан энэ үеэр зарим сурагчидтай уулзаж ярилцсан юм. “За хэцүү байна уу, хөтөлбөрт хамрагдах ямар байна” гэх асуултад ихэнх хүүхдүүд “Эхлээд хэцүү байсан. Одоо бол дассан” хэмээн хариулах аж. “Хоолондоо цадаж байна уу” гэхээр охид нь “тийм”, хөвгүүд нь “гайгүй” гэж хариулна. “За яг үнэнээ хэлчих” гэхээр хөвгүүд “цадахгүй байна” гэж хэлээд инээлдэнэ. Гэртээ 500 гр аягаар хоёр, гурав иддэг хөвгүүд энд ирээд цэргийн нормтой хоолонд ихэнхдээ цадахгүй хэцүү байдаг хэмээн мэргэжлийн хүмүүс

> их сургуулийн багш,
> йгээд нэгэн зэрэг “эрхэм
> ээн хэлээд цэнгэлдэхийг
> нгэлдэх талбайн голд
> к сурагчид дор бүрнээ
> биенээ даган уйлалдах
> агшныг харсан хүмүүс
> арим нь даган нулимсаа
> аа ташиж хүндэтгэлээ
> ж байлаа...”

хэллээ. Тэгэхдээ энэ бол норм, дүрэм журмын дагуу өгдөг шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоосон хоол учир хоолноос авах бүх амин дэмээ авч чадна хэмээж байлаа. Мэдээж өдөр бүрийн ачаалалтай бэлтгэл, багагүй ажил ч тэднийг өлсөхөд нөлөөлдөг бизээ.

## Нулимстай баяр

Бидний иргэдийг орой сургалтад хамрагдаж буй хүүхдүүд бидэнд зориулж бүс бүсээсээ шалгарсан урлагийн тоглолтоо сонирхуулав. Үнэхээр л хаа газар явахад монгол хүүхдүүдийн авьяас, чадвараар дандаа бахархдаг билээ. Энд ч мөн адил Завханы хүүхдүүдийн авьяасыг биширсээр, алгаа хорстол ташсаар нэгэн оройг үдлээ.

2018 оны есдүгээр сарын 19-ний өдөр. Өглөө бүрээн дуу дуугарахад биеийн тамирын хувцастай сурагчид, тэднийг толгойлж буй сонсогчид талбай дээр даруй цуглах аж. Тун удалгүй өглөөний гүйлтээ хийлээ. Энэ үеэр Ерөнхийлөгч Х.Баттулга тэдэнтэй цуг дасгал хийсэн агаад тухайн өдрийн дасгалыг удирдан явуулаа. Хөл, гар халаах дасгалаас эхлээд, сунгалтын дасгал ч хийв. Хамгийн сүүлд хоёр оролтоор гар дээрээ 50 удаа суниаснаар өглөөний дасгал өндөрлөв. Түүний дараа хүүхдүүд өглөөний цайндаа оров. Харин дараа нь өглөөний дасгал хийсэн талбай дээрээ ёслолын хувцастайгаар эргэн цугласан юм. Ерөнхийлөгч Х.Баттулга сургалтад хамрагдсан 1600 хүүхэд бүрт тусгайлан баяр хүргэн, нэг бүрчлэн хамтдаа зураг даруулж, батламж, дурсгалын зүйлийн хамт гардуулав. Мэдээж энэ сургалтад хамрагдаж буй хүүхэд нэг бүртэй зураг даруулсан болохоор чамгүй хугацаа орсныг энд дурдахын хэрэг юун.

2018 оны есдүгээр сарын 20-ны өдөр. Завхан аймгийн төв Улиастай хот, цэнгэлдэх хүрээлэнд “Бид Чингисийн үр сад, Зөв тэмүүлэл-эх оронч манлайлал” сургалтын хаалтын үйл ажиллагаа боллоо. Хүүхдүүдээ харахаар ирсэн эцэг, эхчүүд цэнгэлдэх дүүргэн суух аж. Харин 14 хоногт юу сурснаа тайлагнахаар 1600 хүүхэд сургагч багш нарын хамт талбай дээр үзүүлбэр үзүүлнэ. Нэгэн зэрэг жагсаалын бэлтгэл болон гардан тулааны анхан шатны үзүүлбэрүүдийг хэрхэн сурснаа үзүүлнэ. Ийм олон хүн нэгэн зэрэг хийхээр сүртэй агаад жавхаатай аж. Хажууд зогсож байсан үл таних хоёр хүний нэг нь “Эд нар чинь цэргүүдээс ч илүү сурсан юм бишүү” хэмээн өгүүлэхэд өнөөх нь “дандаа өсвөрийн хүүхдүүд, дээрээс нь наадуул чинь ахлах ангийн боловсролтой болохоор хурдан сурч байгаа л даа” гэж ярилцах нь сонсогдов.



Гэрэл зургийг Ш.ОТГОНЖАРГАЛ

Үнэхээр ч энэ сургалтад хамрагдсан хүүхдүүдээр бахархахгүй байхын аргагүй аж. Бүх үзүүлбэрээ үзүүлж дууссаны дараа эцэг, эхийн өврөөс салаагүй байгаа энэ сурагчдыг 14 хоногийн турш хариуцаж явсан Хууль сахиулахын их сургуулийн багш, сонсогчид ёсолгоо хийгээд нэгэн зэрэг “эрхэм сурагчид баяртай” хэмээн хэлээд цэнгэлдэхийг тойрон одлоо. Цэнгэлдэх талбайн голд жагсаалаараа зогсох сурагчид дор бүрнээ нулимсаа арчин, бие биенээ даган уйлалдах нь өхөөрдөм аж. Тэр агшныг харсан хүмүүс зарим нь өхөөрдөж, зарим нь даган нулимсаа арчиж, зарим нь алгаа ташиж хүндэтгэлээ илэрхийлж байлаа. Үүний дараа Монгол орны өнцөг булан бүрээс ирсэн 3030 морин хуурч цэнгэлдэхийн талбайгаас морин хуурын тоглолтыг цугласан олонд сонордуулсан юм. Тухайлбал, морин хуурчид Монгол Улсын Урлагийн гавьяат зүтгэлтэн Д.Цэвээнравдангийн Дуут нуур, Хөгжмийн зохиолч Ц.Сүхбаатарын Үүлэн бор, Н.Жанцанноровын Монгол аялгууг эгшиглүүлсэн юм. Эцэст нь Ерөнхийлөгч Х.Баттулга эл үйл ажиллагааг хааж “Завханчууд аа, Монгол Улсын маань ирээдүй болсон хүүхэд залуусыг өвөг дээдсээрээ, түүх уламжлалыг хүндэтгэж, эх орон байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах, эх оронч үзэл, хүмүүжилтэй, оюунлаг зөв монгол иргэн болгон төлөвшүүлэх зорилгоор “Бид Чингисийн үр сад-Зөв тэмүүлэл, эх оронч манлайлал” сургалт, хөтөлбөр ийнхүү амжилттай өндөрлөж байна. Бүх оролцогчдод дахин чин сэтгэлийн баяр хүргэе. Монгол бахархал болсон, үлгэр жишээ, зөв тэмүүлэл, эх оронч манлайлалтай сурагч хөвгүүд охидоороо бахархаж байна. Бусад аймаг, хотууд энэ зүйлийг даган дуурайж, бахархаасай гэж хүсье” хэмээн хаалтыг үгийг хэлснээр эл сургалт албан ёсоор өндөрлөсөн юм.

## Ерөнхийлөгчийн орон нутаг дахь томилолт

Анхлан Ерөнхийлөгчийн хэлсэн үгийг ажил хэрэг болгон санаачилсан хүн нь УИХ-ын дэд дарга Я.Санжмятав аж. Харин эл санаачилгыг ажил хэрэг болгосон хүн нь Завхан аймгийн засаг дарга Д.Батсайхан болон түүний тамгын газрынхан, Завхан нутгийн иргэд билээ. Энэ талаар УИХ-ын дэд дарга Я.Санжмятав “Энэ хөтөлбөр бол бидний хэдэн дарга нарын хийсэн ажил огтоос биш. Бидэнд үр хүүхдээ итгэн өгч явуулсан нутгийн иргэдийн хүч юм” хэмээн хөтөлбөрийн төгсгөлд онцолж байсан юм. Харин Завхан аймгийн Засаг дарга Д.Батсайхан “Хөтөлбөрийн хүрээнд олон олон саад бэрхшээл гарч байлаа. Тэгэхдээ бид тухайн бүрт нь шийдвэрлэн амжилттай хэрэгжүүлэн дуусгалаа. Тухайлбал, зарим хүмүүс хүүхдүүдээр шоудлаа. Ийм юманд мөнгө зарахынхаа оронд Завхан хүртэлх замаа засдаг болоосой гэх мэтээр хэлж, энэ сургалтыг эсэргүүцэж гарын үсэг хүртэл цуглуулсан ч удаа бий. Гэсэн ч бид тус сургалтыг ч амжилттай дуусгалаа. Мөн энэ жил тавих ёстой замаа ч тавьж дуусгана. Хэсэг газар зам тавихад дутаад байсан мөнгөө ч бид олж, хоёр хоногийн өмнө газрын үсэг зурж баталгаажууллаа. Үндсэндээ дараа жил гэхэд Завхан аймаг хатуу хучилттай замаар Улаанбаатар хоттой бүрэн холбогдоно” хэмээн өгүүлж байсан юм. Ийнхүү Монгол Улсын Ерөнхийлөгчийн Завхан аймаг дахь томилолт “Бид Чингисийн үр сад, Зөв тэмүүлэл-эх оронч манлайлал” сургалтын явцтай танилцаж, 3030 морин хуурчдын өв соёлоо түгээж буй тоглолтыг үзэж, тэдэнд урам хайрлаж, мөн Завхан аймагт баригдсан “Усан бассейн бүхий спорт ордон”-ы нээлтэд оролцсоноор өндөрлөлөө.




















ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

# ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙНХЭН ӨВӨЛД БЭЛЭН

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

"Бид өвөлд бэлэн" өдөрлөг 12.00 цагаас албан ёсоор нээлтээ хийсэн юм. Өдөрлөгт ЗТХЯ-ны Тээвэр зохицуулалтын хэлтсийн дарга Г.Гантулга, "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын захирал П.Дэлгэрнаран, "Хот хоорондын тээвэр эрхлэгчдийн холбоо" ТББ-ын тэргүүн Т.Хүрэлхүү, холбогдох газрын дарга мэргэжилтэн болон Улс, хот хоорондын нийтийн тээврийн тээвэрлэгч 60 гаруй байгууллага оролцлоо. Энэхүү өдөрлөгийг нээж Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын захирал П.Дэлгэрнаран үг хэлсэн юм. Тэрбээр "Энэ жилийн "Өвөлд бид бэлэн" өдөрлөгөөр хот хоорондын тээврийн үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжүүд өвөлжилтийн бэлтгэл ажлаа хэрхэн хангасан талаар газар дээр нь ирж шалгаж байгаагаараа онцлогтой. Мөн нийтийн тээвэрт үйлчилж байгаа стандартыг бид хэрхэн хэрэгжүүлж байна гэдэг асуудлаа ярилцах, тээврийн хэрэгслийн бэлэн байдлыг харуулж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслүүдээ дэлгэж шалгуулж байгаа юм. Үүнээс гадна, тухайн аж ахуйн нэгж дотроо өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах асуудлаар ямар ажил зохион байгуулсан болон ямар үр дүнд хүрэв гэдгээ тайлан маягаар сонсож, ярилцах ажлыг нэмэлтээр зохион байгуулж байна.



Дөрвөн зүг, найман зовхист тээвэрлэлт хийж буй эдгээр аж ахуйн нэгжүүд өвөлд бэлэн байгааг энэхүү өдөрлөгөөс харж болохоор байна" гэсэн юм. Үүний дараа уг өдөрлөгт хүрэлцэн ирсэн хүмүүс "Хараацайн жигүүр" ХХК-ийн авто аж ахуй болон хот хооронд зорчигч тээврүүд өвөлжилтийн бэлтгэл ажлаа хэрхэн хангасан байгаа байдалтай танилцсан юм.

> ...Биднийг тэр автобус руу ороход халуун дулаан орчин, тав тухтай байдал угтсан бөгөөд хүмүүст халуун цай болон кофегоор үйлчилж байсан юм. Энэхүү автобус нь Хархорин-Улаанбаатар чиглэлд явдаг...

## Халуун цай, кофегоор үйлчилж байв

Өдөрлөгт оролцогч аж ахуйн нэгжийн төлөөллүүд "Нийтийн зорчигч тээврийн стандарт, гэрээнд заасан тодорхой заалтуудыг биелүүлж байгаа эсэхийг жил бүр өвөлд бэлэн эсэхийг шалгадаг. Тээврийн хэрэгсэл, техникийн бүрэн бүтэн байдал зэргийг хангуулахаас гадна осол саатал гарсан үед тухайн тээвэрлэлтийн явцад техникийн түргэн тусламжийг хэрхэн үзүүлэх, ямар тусламж үйлчилгээг цаг алдалгүйгээр хүргэх тал дээр бэлэн байдлыг хангуулахыг зорьдог. Үүний жишээ болгож тээврийн хэрэгслийн бүрэн тоноглосон түргэн тусламжийг авчирсан" хэмээн танилцуулж байв. Энэ үеэр бусад хот хооронд зорчигч тээврээс ялгарч буй нэг автобус байв. Биднийг тэр автобус руу ороход халуун дулаан орчин, тав тухтай байдал угтсан бөгөөд хүмүүст халуун цай болон кофегоор үйлчилж байсан юм. Энэхүү автобус нь Хархорин-Улаанбаатар чиглэлд явдаг. Иргэдийнхээ болон өөрийнхөө тав тухыг бодоод автобусаа хэрхэн тохижуулсан талаар жолооч Ц.Мияасүрэн автобусыг нь сонирхсон хүн болгонд хариулж байв. Тэрбээр "Манай автобус урд, ард зам болон дотор талбайгаа бичдэг камертай. Иргэдийн тав тухыг бодож халуун цай, кофегоор үйлчилж байна. Мөн өөрийнхөө тав тухтай байдлыг бодоод өөрийнхөө эргэн тойрныг тохижуулсан" хэмээн ярьсан юм. Улс, хот хоорондын 73 ААН-ын 970 гаруй тээврийн хэрэгслийн 1100 мэргэшсэн жолооч нийтийн зорчигч тээврийн үйлчилгээнд ажиллаж байгаа юм байна. Зорчигч, үйлчлүүлэгч нарт тав тухтай аюулгүй тээврийн хэрэгсэл, дадлага туршлагатай жолооч нараар үйлчлэх, өөр өөрийн байгууллагад хэрэгжүүлж буй туршлагаа солилцон 2018-2019 оны өвлийн тээвэрлэлтэд бэлэн болсноо ийнхүү харуууллаа.

## Цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээг жолооч нарт байнга хүргэдэг

Улс, хот хооронд зорчигч тээвэрлэлт гүйцэтгэж буй нийслэл хотод байршилтай 23 аж ахуйн нэгж, байгууллагын 471 тээврийн хэрэгслийг шалгахад 90-ээс дээш хувьтай 12, 70-89 хувьтай дүгнэгдсэн 11 аж ахуйн нэгж, байгууллага байгааг энэ үеэр танилцуулсан юм. Ийнхүү хот хооронд зорчигч тээврүүдийн өвөлжилтийн бэлтгэл ажилтай танилцаж дууссан юм. Энэ үеэр өвөлжилтийн бэлтгэл ажил хэр хангагдсан талаар АТҮТ-ийн тээвэр хариуцсан дэд захирал Ш.Батсайханаас тодрууллаа. Тэрбээр "АТҮТ-өөс зохион байгуулж буй "Бид өвөлд бэлэн" өдөрлөгийн тов хоёр сарын өмнө зарлагддаг. Тиймээс аж ахуйн нэгжүүд өвөлжилтийн бэлтгэл ажлаа бүрэн хангасан байдаг. Аж ахуйн нэгжийн төлөөлөл болгож нэг байгууллагад авчирсан боловч бүх тээврийн хэрэгсэлд шаардлагатай дагалдах хэрэгслүүд бүгд байна гэсэн үг. Тиймээс автотээврийн үйлчилгээнд зорчигч тээврийн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагууд өвөлжилтийн бэлтгэл ажлаа бүрэн хангасан бөгөөд бид өвөлд бэлэн" гэв. Түүнчлэн, АТҮТ нь УЦУОШГ-тай хамтран ажилладаг бөгөөд цаг агаарын долоо хоногийн мэдээг урьдчилан авч жолооч нарт сэрэмжлүүлэг мэдээ байнга хүргэдэг байна. Мөн албан ёсны баталгаатай, тээврийн хэрэгсэл, мэргэшсэн жолоочтойгоор үйл ажиллагаа явуулдаг эдгээр аж ахуйн нэгжүүд даатгалын компаниудтай хамтарч ажилладаг. Тиймээс аливаа осол, саатал гарсан тохиолдолд иргэд, зорчигчдод хүндрэл, чирэгдэл үүсгэхгүйгээр зохион байгуулалтын үйл ажиллагааг авч ажилладаг гэж байсан юм. Ийнхүү зорчигч тээврүүдийн үйл ажиллагаатай танилцаж дууссаны бөгөөд тээвэрчдийн дунд ур чадварын тэмцээн зохион байгуулж, шагнал гардуулснаар энэхүү өдөрлөг дууссан юм.



# УНДРАХ ҮЛ ХӨДЛӨХ ЗУУЧЛАЛЫН ТӨВ

## БАЯНГОЛ ДҮҮРЭГ

БГД 18-р хороо модны 2 GRAND HILL-д 12 давхарын 12 давхарт 2000онд ашиглалтанд орсон 68,2м2 гал тогоо тусдаа 2 өрөө байр зарна. **Үнэ: 95 сая**

БГД 20-р хороо 2008 онд ашиглалтанд орсон 2100м2 хашаатай 112м2 байшинтай хашаа байшин худалдана. **Үнэ: 450 сая**

БГД 2-р хороо Баруун 4 замын хажуу талд hill side-д 2012 онд ашиглалтанд орсон 47м2 2 өрөө байр зарна. **Үнэ: 87сая**

БГД 2-р хороо шинэ хотхон 2-р байранд 2011 онд ашиглалтанд орсон 48.25м2 3 өрөө байр зарна. **Үнэ: 72сая**

БГД 17-р хороо ахуй үйлчилгээний уулзвар дээр 26-р байр 2006 онд ашиглалтанд орсон 75.6м2 3 өрөө байр зарна. **Үнэ: 140сая**



БГД 4-хороо Ханбүргэдэй 3-р байр 1985онд ашиглалтанд орсон 29м2 2өрөө байр зарна. **Үнэ: 87 сая. Утас: 95001624, 88971624**

БГД 4-р хороололд 2015 онд ашиглалтанд орсон 59,5 м2 3өрөө байр зарна. **Үнэ: 130 сая**

БГД Гэмтэлийн замын эсрэг талд төв зам дагуу 2008 онд ашиглалтанд орсон 366 м2 хашаа байшин зарна. **Үнэ: 50 сая**

БГД 11-р хороо бичилд 2010 онд ашиглалтанд орсон 26м2 1өрөө байр зарна. **Үнэ: 41 сая**

БГД 10-р хороолол голдэн парк хороололд 2010 онд ашиглалтанд орсон 44м2 2өрөө байр зарна. **Үнэ: 70 сая**

БГД 16-р хороо Ганданд 259м2 газартай 62,17 м2 байшинтай хашаа байшин яаралтай зарна. **Үнэ: 90 сая**

БГД 3-р эмнэлэг 5-р хороо 2010 онд ашиглалтанд орсон 65,93м2 2 өрөө байр зарна. **Үнэ: 89 сая**

БГД 9-р хороо 33-р байр 2003 онд ашиглалтанд орсон 44м2 2 өрөө байр зарна. **Үнэ: 65 сая**

БГД 10-р хороололын чанх хойд талд 2014 онд ашиглалтанд орсон 38,4м2 1 өрөө байр зарна. **Үнэ: 64 сая**

БГД 7-р хороо Говь сауны баруун талд байрлах 77А байранд маш дулаан граж зах зээлийн үннэс хямд зарна **Үнэ: 12 сая**

## БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ

БЗД ахмадын хороолол 2өрөө 60мк 2008 онд ашиглалтанд орсон. **Үнэ: 84сая**




БЗД цэцэрлэгт хүрээлэнгийн чанх хойд талд 364-р байранд 82м2 3 өрөө байр зарна. **Үнэ: 246 сая**

БЗД 16-р хороололын Саруул тэнгэр хотхонд 63,38м2 3 өрөө байрыг зарна. Бүрэн засвар хийгдсэн. **Үнэ: 92 сая**

БЗД 5-р хороо Монел хуучин эцэс дээр Сургууль цэцэрлэгтэй ойрхон 700м2 газартай хашаа байшин зарна. **Үнэ: 35 сая**

БЗД 5-р хороо Жуков хотхоны 49-а байраны 1давхарт үйлдвэр үйлчилгээ явуулах боломжтой 2 өрөө байр зарна. **Үнэ: 65 сая**

БЗД 22-р Хороо алтан өлгий эцсийн буудал 200мк, 0.7 газартай 380вт тогтой үйлдвэр үйлчилгээ явуулах боломжтой хашаа байшин зарна. **Үнэ: 60 сая**

БЗД 22-р хороо алтан өлгий 16-р гудамж 444м2 нам даралт болон цахилгаан хосолсон, 00-өрөө дүүш дотроо хашаа байшин зарна. **Үнэ: 80сая**

БЗД 26-р хороо олимп хотхон 424-р байр 2016онд ашиглалтанд орсон 12 давхарын 7давхарт 51.3м2 2 өрөө байр зарна. **Үнэ: 120 сая**

БЗД 4-хороо шинэ цэргийн хотхон 28B байранд 2018 4 сард ашиглалтанд орсон бүрэн цутгамал 40м2 1өрөө байр зарна. **Үнэ: 56 сая**

БЗД 4-хороо шинэ цэргийн хотхон 28B байранд 2018 4сард ашиглалтанд орсон бүрэн цутгамал 44.26м2 1 өрөө байр зарна. **Үнэ: 60 сая**

БЗД 4-хороо шинэ цэргийн хотхон 28B байранд 2018 4сард ашиглалтанд орсон бүрэн цутгамал 40.7м2 1өрөө байр зарна. **Үнэ: 54.2 сая**

БЗД 4-хороо шинэ цэргийн хотхон 28B байранд 2018 4сард ашиглалтанд орсон бүрэн цутгамал 38.61өрөө байр зарна. **Үнэ: 53 сая**

БЗД 4-р хороо шинэ цэргийн хотхон 28B байранд 2018 4 сард ашиглалтанд орсон бүрэн цутгамал 44.26м2 1өрөө байр зарна. **Үнэ: 58.7сая**

БЗД офицер өндөр цайз захын чанх хойд талд 56м2 дуу чимээ бага харуул хамгаалалт маш сайн 2 өрөө байр зарна. **Үнэ: 60 сая**

БЗД 4-хороо 49B байранд 38,8м2 1 өрөө сууц зарна гадна орчин цэвэрхэн 24цагийн харуул хамгаалалттай маш сайн ярина. **Үнэ: 57 сая**

БЗД 24-р хороо да хүрээ захын чанх хойд талд 576м2 хашаатай 2004 онд ашиглалтанд орсон 3өрөө хашаа байшин зарна. **Үнэ: 27 сая**

БЗД 26-р хороо саруул хотхонд 42м2 12 давхарын 3 давхарт хотын А зэрэглэлд 2 өрөө байр зарна. **Үнэ: 87 сая**

БЗД 22-р хороо Цайз захын хойно 348м2 нийтийн байр зах зээлийн үнээс доогуур зарна 2017 онд ашиглалтанд орсон 20 цонхтой дотроо 3 нойлтой 380вт холбогдсон бүрэн камержсэн өрөө дүүргэлт маш сайн. **Үнэ: 140 сая**

БЗД 19-р хороо цайзд 124м2 2 давхар 2008 онд ашиглалтанд орсон өдөрт дундажаар 600-800 мянга ордог бүрэн камержсэн дэлгүүрийн тавилга дагалдуулж өгдөг 380ВТ тогонд холбогдох боломжтой олны мэдхээр зүүн алтан өлгийд байрлалтай. **Үнэ: 55 сая**

БЗД 25-р хороо олны мэдхээр натур төвийн урд HOME LAND яг баруун талд 2016 онд ашиглалтанд орсон 10 давхар байрны 8 давхарт 70.7м2, 3 өрөө байр зарна. **Үнэ: 140сая**

БЗД Офицер баянзүрх хотхоны 108-р байранд 12 давхарын 8 давхарт 2011онд ашиглалтанд орсон 55м2 2 өрөө байр зах зээлийн үнээс хямд зарна. **Үнэ: 85 сая**

БЗД 14-р хороо жоби 72 замын эсрэг талд 57-р байранд 2005 онд ашиглалтанд орсон 5 давхарын 5давхарт 73.4м2 3 өрөө байрыг зах зээлийн үнээс хямд зарна. **Үнэ: 95сая**

БЗД X апартмэнт офицерь 1өрөө байр 30мк 2016 онд ашиглалтанд орсон. **Үнэ: 58 сая**



БЗД Шар хад 9-р хороо Ээж хайрханд 480м2 хашаатай 80м2 байшинтай зам дагуу нүүрэн талын хашаа байшинг зах зээлийн үнээс доогуур зарна. **Үнэ: 30 сая**

БЗД 27-р хороо Дунд дарь эх 32-р гудамж 0.7м2 хашаатай төвийн шугам 380вт тогтой болход бэлэн хашаа байшин зарна. **Үнэ: 28 сая**

БЗД 14-р хороо сувдан сондор 2015 онд ашиглалтанд орсон 11 давхарын 10 давхарт 34м2 байр зарна. **Үнэ: 47 сая**

БЗД 6-р хороо hard rock хажуу талд 12 давхарын 8 давхарт 65.4м2 2 өрөө байр зах зээлийн үнээс хямд зарна. **Үнэ: 130 сая**

БЗД Жуков 4-р хороо 2010 онд ашиглалтанд орсон 10 давхар байрны 8 давхарт 122.5м2 4 өрөө байр зарна. **Үнэ: 150 сая**

БЗД 11-р хороо товчоонд 2008 онд ашиглалтанд орсон 100м2 3 өрөө хашаа байшин зах зээлийн үнээс хямд зарна. **Үнэ: 50 сая**

БЗД 23-р хороо баатар хайрханд 2.6га талбай 1.6га ашигтай талбатай 2004 онд ашиглалтанд орсон 380вт холбогдсон 4 машины гражтай хашаа байшин зарна. **Үнэ: 90 сая**

БЗД 26-р хороо Олимп хотхонд 2014 онд ашиглалтанд орсон 49.3м2 2 өрөө байр зарна. **Үнэ: 95 сая**

БЗД 13-р хороолол халдвартын шинэ 3 өрөө байр 89мк. **Үнэ: 164сая**

БЗД ДА хүрээ захын ард хашаа байшин 500мк газар 24мк байшин. **Үнэ: 20сая**

БЗД түмэннаст хотхон 2өрөө 38мк **Үнэ: 70сая**

БЗД гачуурт хашаа байшин зарна 850мк газар 8x8 64мк байшин. **Үнэ: 40сая**

БЗД Жуковт хагас подвол 63мк 2 өрөө. Үнэ: 73 сая

## СҮХБААТАР ДҮҮРЭГ

СБД 5-р хороо 50мянгат голомт хотхоны зүүн талд 48мк 2 өрөө байр зарна. **Үнэ: 93 сая**



СБД 11 хороо Шинэ замын буудал дээр өмчлөлийн гэрчилгээтэй 1064мк газар. **Үнэ: 660 сая**

СБД 17-р сургуулийн буудал 1800мк газар уг газар төв зам дагуу. **Үнэ: 680 сая**

СБД 13-р хороо ногоон талбай 5-н буудалд хашаа байшин 500мк газар 30мк. **Үнэ: 31 сая**

СБД 16-р хороо Дамба хаша байшин 07 60мк байшин. **Үнэ: 20 сая**

СБД 15-р хороо Архустайд 410мк 8 нэрийн дэлгүүр зарна. **Үнэ: 175 сая**

СБД 16-р хороо бэлх 180мк 2 давхар байшин 180мк 4 өрөө. **Үнэ: 86 сая**

СБД Дамба 16-р хороо 80мк 0,9га газартай. **Үнэ: 48 сая**

СБД Барилгчдын 26.74мк. **Үнэ: 215 сая**

СБД 11-р хороо хангай хотхонд 38,2 мк бүхий 2 өрөө байр зарна. **Үнэ: 62 сая**

СБД 19-р хороо хандгайт ундраа зуслан явах замд 2000мк газар. **Үнэ: 53 сая**

СБД 1-р хороо нарны зам цамын цагдаа үйлдвэрчин хотхонд Б1 давхарт 26,8мк бүхий 6нэрийн дэлгүүр. **Үнэ: 40 сая**

СБД 17-р хороо Дамбдаржаа одоо ажилаж байгаа дэлгүүр түргэн хоолны газар 512мк2 давхар байшин.

СБД авто Плаза Газар зарна 510мк. **Үнэ: 310сая**

## СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ

СХД, Саппорогийн уулзвар, ЭС БИ-төвтэй 186-р байр. **Үнэ: 62 сая**

СХД, 32-р хороо Бордоо, Хайрханд хашаа байшин. **Үнэ: сая**

СХД 1-р хороолол 32р байрны урд 8-нэрийн дэлгүүр 406м2. **Үнэ: 771 сая**

СХД 24-р хороо Баруун салаанд хашаа байшин 1300м2. **Үнэ: 72 сая**

СХД 36-р хороо чулуутад 116 м2. **Үнэ: 41 сая**

СХД 1-р хороо Орбит хашаа байшин. 1095м2. **Үнэ: 59 сая**

СХД 25-р хороо Хайрхан хашаа байшин 488м2. **Үнэ: 35 сая**

СХД 9-р хороо малчны гудманд хашаа байшин 85м2. **Үнэ: 25 сая**

СХД бага наран 8 нэрийн дэлгүүр. 96м2. **Үнэ: 50 сая**

СХД 18-р хороо 59м2. **Үнэ: 76 сая**

СХД Их наран 4-р хороонд хашаа байшин. 90 м2. **Үнэ: 45 сая**

СХД 23-р хороо хангайд хашаа байшин 49м2. **Үнэ: 34 сая**

СХД Бариуун салаа 7-р хороо Дэнж 6-н нэрийн дэлгүүр. **Үнэ: 50 сая**

СХД Орчлон хотхон 3 өрөө 56м2 байр, грашийн хамт. 2018 оны 9-р сард ашиглалтанд орсон. **Үнэ: 95 сая**



СХД 12-р хороо хангайд байрлах обект 880м2 газар 2014 ашиглалтанд орсон. **Үнэ: 880 сая**

СХД 22-р хороо Хилчин (орбит) эцэс буман өлзий хотхоны баруун талд хашаа байшин. **Үнэ: 48 сая**

СХД Их наран 26-р хороо мандал овоо 8-н нэрийн дэлгүүр. **Үнэ: 85 сая**

СХД 7-р хороо хилчин хотхон 7-р байр 60 м2 3 өрөө байр зарна. **Үнэ: 72 сая**

## ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ

ЧД 6-р хороо 6-р хороолол 24-р байр 1983 онд ашиглалтанд орсон 38м2. **Үнэ: 70 сая**

ЧД 7-р хороо зурагтын хуучин эцэс 2008 онд ашиглалтанд орсон 200м2 дэлгүүр зарна. **Үнэ: 160 сая**

ЧД 13-р хороо сургуулийн 34 2002 онд ашиглалтанд орсон 93м2 байшинтай хашаа байшин зарна. **Үнэ: 45 сая**

ЧД Уран мандалын буудал сурагчын 31 2008 онд ашиглалтанд орсон 670м2 хашаа байшин зарна. **Үнэ: 24 сая**

ЧД 9-р хороо цагаан байрнаас дээш 2012 онд ашиглалтанд орсон 56м2 байшинтай хашаа зарна. **Үнэ: 35 сая**

ЧД Ар согоот 1-р гудам 700м2 2012онд ашиглалтанд орсон 380 тогтой хашаа байшин зарна. **Үнэ: 45 сая.**

ЧД Дэнжийн мянга булгийн 6Д 2013 онд ашиглалтанд орсон худаг буудалдаа ойрхон хашаа байшин зарна. **Үнэ: 35 сая**

ЧД баянбүрдэд 3өрөө байр зарна 47мк. **Үнэ: 100сая**

## ХАН-УУЛ ДҮҮРЭГ

ХУД зүүнбаян уул хашаа байшин 2 өрөө 980мк газар. **Үнэ: 25 сая**

ХУД 15-р хороо зуслангийн байшин 134мк. **Үнэ: 135 сая**

ХУД нисэхийн эцэст хашаа байшин зарна. 64мк байшин 530мк газар. **Үнэ: 46 сая**

ХУД UBTOWN 86.57мк бүхий 3 өрөө. **Үнэ: 160 сая**

ХУД 7-р хороо обект 90 мк. **Үнэ: 137сая**

ХУД Ажилчдын гудамж хашаа байшин. **Үнэ: 140 сая**

ХУД Вива сити 15-р байр 2 өрөө 49.5мк. **Үнэ: 85 сая**

ХУД Ярмаг 2-р буудал арцатын 4-р гудамж хашаа байшин 174мк байшин. **Үнэ: 75 сая**

ХУД Нисэх-н 7-р байр хуучинаар-37мк 3 өрөө. **Үнэ: 90 сая**

ХУД Цэлмэг хотхонд 3 өрөө 85.6мк. **Үнэ: 144 сая**

ХУД 3-р хороо 19-н буудал 2 өрөө 48мк. **Үнэ 64 сая**

ХУД Наран хотхон 3 өрөө 86мк. **Үнэ: 184сая**

ХУД орчлон сургуул хойно 3 өрөө байр 107мк. **Үнэ: 200сая**

**Бүх заруудыг 95001622 88971622 95001627 88971627 дугааруудаас лавлана уу**

ӨДРИЙН СУРВАЛЖИЛГА

# “БИД ИРГЭДИЙН ТӨЛӨӨ Л ТӨРИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭЖ ЯВАА”

...Баярлалаа гэж хэлэхээсээ илүү зүхэхдээ амархан шүү манай иргэд. Бид осол аюулаас урьдчилан сэргийлж өөрсдийнх нь төлөө л төрийн нэрийн өмнөөс үүрэг гүйцэтгэж яваа. Зөвшөөрөлгүй жагсаал цуглаан тараах үеэр ээж шиг минь хүн ирээд энгэрээс зүүгдээд заамдаад авдаг...







Ц.ЧАНДМАНЬ-ЭРДЭНЭ

ts.chandmanierdene@gmail.com

Бүрэн тоноглол бүхий цагдаагийн хувцас өмссөн сэтгүүлчид Police гэсэн бичигтэй тунгалаг бамбайг ганц гараараа арай ядан өргөнө. Тас хар өнгөтэй цагдаагийн хамгаалалтын хуяг, тоноглол, дуулга нь хэлхсэн төмөр, гархин хуягтай зүйрлэхгүй хөнгөн хэдий ч бидэнд нэг гараараа даахад хүнд санагдана. Өнгөрсөн долоо хоногийн баасан гарагт “Одонт хороо” хэмээн алдаршсан дотоодын цэргийн 05 дугаар ангид эрэн сурвалжлах сэтгүүлчдийн “Эрх зүйн сургалт, өдөрлөг”-өөр нийтийг хамарсан эмх замбараагүй нөхцөл байдал үүсэн тохиолдолд цагдаа хэрхэн ажилладаг дадлага сургалтад 40 гаруй сэтгүүлч хамрагдсан юм. Үнсэн өнгөтэй тэнгэрийн доор хацар, гар хайрч ороосон жиндүү салхинд сүр жавхлантай дэрвэх Монгол Улсын төрийн далбаа эх оронч сэтгэлийн галыг зүрхэнд бадамлуулна. Цэргийн хашаанд аравтын зохион байгуулалтад орсон гурван аравтын 30 цагдаа эгнэн жагсжээ. Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн үзүүлэнгийн дөрвөн самбар дээр цагдаагийн хэвлэл мэдээлэл олон нийттэй, харилцах албаны дарга Б.Баатархүү хуулийг задлан тайлбарлаж өгөв. Тэрбээр цагдаагийн албан хаагчид тушаалын дагуу үүрэг гүйцэтгэдэг болохыг дурдсан юм. Хацар шахаж хавчсан хүнд дуулга, мөр дарж, амьсгал боосон хамгаалалтын хантааз бүхий хөдөлгөөн хязгаарлах 10 гаруй килограммын жинтэй хувцас, бамбайгаар тоноглогдсон бидэнд цагдаагийн албан хаагчид үзүүлэх сургалт сонирхууллаа.

Мөр шахаж хоорондоо зай гаргалгүй хамгаалалтад зогсох аравтын завсраар исгэрэх салхи үл нэвтэрмээр. Нэг цул бие хүн шиг зэрэг хөдлөх тэд усны урсгал мэт урагш түрнэ. Цагдаа нар өмсгөл хувцсандаа түүртэхгүй шалмаг аж. Тэдэнтэй зэрэгцэн эсэргүүцлийн жагсаал тараах, үзүүлэх сургалтад оролцох үед айдас түгшүүрийн мэдрэмж бүрхээд ирэв. Командаар урагш алхаж “Хойшоо, хойшоо” хэмээн хүч түрэн зугуухан хаалт хийж байхдаа хамт үүрэг гүйцэтгэж байгаа нөхрөө анхаарах хэрэгтэй ажээ. Уриа хашхирч лоозон барьсан энгийн иргэд хар хамгаалалтын өмсгөлийн цаана өөртэй нь адил хүний бие байгаа гэдгийг умартан улангасан дайрах үед энэ сэтгэл хөдлөлийн айдас түгшүүр дээд цэгт хүрч мэдрэгдэв. Энэ үед жинхэнэ үймээний ард юу болдгийг бодохгүй байж чадсангүй. Шахаж түлхэх, бамбай хувцас хэрэгслийн аль таарсан газраас барьж, гудчиж татах үед үүрэг гүйцэтгэж байсан нэг сэтгүүлч хөл алдан үймээн дунд газар унаж харагдлаа. Түүний дээгүүр гишгэлж, унасан дээр нь нэмж яахаас ч буцахгүй үйлдэл үзүүлэх үймээн дэгдээгчдийн гараас нэг цагдаа сэтгүүлчийг суга татан хамгаалалтад авч арын эгнээнд шилжүүллээ. Энэ үйлдэл нүд ирмэхийн зуурт өрнөсөн юм. Бэлтгэгдсэн албан хаагчийн мэргэжлийн ур чадвар шалмаг бөгөөд гайхалтай. “Амар тайван амьдралын төлөө хамтдаа” уриатай цагдаагийн албан хаагчид иргэдийн талархал, хараал хоёрыг тэнцүү хүртдэг аж. Сургалтад оролцож байсан залуу цагдаа “Баярлалаа гэж хэлэхээсээ илүү зүхэхдээ амархан шүү манай иргэд. Бид осол аюулаас урьдчилан сэргийлж өөрсдийнх нь төлөө л төрийн нэрийн өмнөөс үүрэг гүйцэтгэж яваа. Зөвшөөрөлгүй жагсаал цуглаан тараах үеэр ээж шиг минь хүн ирээд энгэрээс зүүгдээд заамдаад авдаг. Та болиоч гэж хэлэхээр үг сонсохгүй. Гарыг нь тавиулах гээд хүрэх төдийд үсрээд уначихдаг. Нэгтээ тангараг өргөсөн төрийн хар хүн учир иргэдийнхээ өлмий дор л явах ёстой гэж боддог хүн олон байдаг юм шиг санагддаг. Би бас хэн нэгний хүү , эцэг, хань гэдэг талаас нь хараасай гэж хүсдэг” хэмээн өгүүлсэн нь үе үеийн олон мянган алба хаагчдын сэтгэлийн үг мэт санагдаж байсан юм. 20 минутын үзүүлэх сургуулилтад оролцохдоо мэдэхгүйн улмаас буруу ойлгож явсан олон зүйлийг ухаарсан. Иймээс сэтгүүлч бид цагдаа хүч түрлээ. Цагдаа иргэдийн эрхэд ноцтойгоор халдлаа гэж түрүүлж мэдээлэхээсээ илүү дотогшоо гүн нэвтэрч шалтгааныг мэдээлэх үүргийг илүү ойлгосон. Сургуулилт өндөрлөж цагдаагийн хамгаалалтын өмсгөлийг тайлах үед мөрөн дээрээс бул чулуун ачаа оргүй авсан мэт санагдаж байсан юм. Тэдний өмсгөл хүнд, гүйцэтгэж буй үүрэг нь хүнд харин сэтгэл нь цагаан юм.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## Б.Махбалын цагдан хорих хугацааг нэг сараар сунгажээ

Ц.ЧАНДМАНЬ-ЭРДЭНЭ

ЗТХЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Б.Махбал нь архи уусан үедээ согтуурч, Зам, тээвэр хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Т.Гомбосүрэнгийн аминд хүрсэн харамсалтай хэрэг өнгөрсөн сард гарсан.

Хэрэг гарсны маргааш өдөр наймдугаар сарын 10-ны өдөр сэжигтэн Б.Махбалыг ШШГЕГ-ын харьяа цагдан хорих 461 дүгээр ангид саатуулсан байдаг. Түүнийг цагдан хорих хугацаа есдүгээр сарын 10-нд дууссан прокурорын байгууллагаас үргэлжлүүлэн хорих саналаа шүүхэд хүргүүлжээ. Шүүхээс сэжигтнийг үргэлжлүүлэн нэг сар цагдан хорих шийдвэрийг гаргасан байна. Б.Махбалыг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1-т зааснаар эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байгаа юм. Хуульд зааснаар хэрэв Б.Махбалын гэм буруутай нь тогтоогдвол 8-15 жилийн хорих ялаар шийтгүүлэх юм байна.

## ТЖАТ-д 132 хүнийг сонгон шалгаруулалтгүй томилжээ

Ц.ЧАНДМАНЬ-ЭРДЭНЭ

Төрийн албаны удирдах ажилтны улсын зөвлөгөөн энэ сарын 21, 22-ны өдөр Төрийн ордонд боллоо. Зөвлөгөөнд бүх шатны төрийн байгууллага, засаг захиргааны нэгжийн удирдах 800 ажилтан оролцсон юм. Зөвлөгөөний үеэр УИХ-ын дарга М.Энхболд хэлсэн үгэндээ “Төрийн алба олон жилийн турш улстөржилтийн талбар болов. Төрийн албан хаагчдаас Төрийн албаны зөвлөлд 2015 онд 626, 2016 онд 630, 2017 онд 514 гомдол маргаан ирүүлсэн нь ажлын өдөр бүр хоёр гомдол ирж байна гэсэн үг. Энэ нь төрийн удирдах албан тушаалтнуудын үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрт ихээхэн хуудуу байгааг харуулж байгаа хэрэг. Мөн өнөөдрийн байдлаар Төрийн албаны зөвлөлийн сонгон шалгаруулалт, дүгнэлтгүйгээр яам, агентлагийн удирдах албан тушаалд 132 хүнийг дур мэдэн томилоод, ажиллуулж байна.

Гэмт хэрэг үйлдсэн, албан үүргэтээ тэнцэхгүй байгаа, хууль зөрчсөн гэх мэт шалтгаанаар 2017 онд 320 албан хаагч ажлаасаа халагдсан байна. Энэ мэт олон шалтгаанаас улбаалан монгол төрийн тогтвортой байдал алдагдахад хүрч болзошгүй болжээ” хэмээн мэдэгдсэн юм.



Улаанбаатарт:



Маргааш

Өдөр +19
Шөнө +5



Нөгөөдөр

Өдөр +18
Шөнө +6

## ӨДРИЙН ЗУРХАЙ



**НАМРЫН ДУНД ЦАГААГЧИН ТАХИА САРЫН ШИНИЙН 15. ЕСӨН УЛААН МЭНГЭТЭЙ ШАРАГЧИН ХОНЬ ӨДӨР**

**Үс засуулбал:** *Өлзийтэй сайн.*

**Наран ургах, шингэх:** *06.42-18.44*



Тухайн өдөр гахай, туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд зэрэг сайн. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус муулах, хишиг даллага дуудуулах, насан бүтээл хийлгэх, эрдэнийг гадагш өгөх, мал худалдан авах, мал түгээх, сахил санваар авах, огторгуйн үүдийг боох, их хүмүүнтэй уулзахад сайн. Хануур, төөнүүр хийлгэх, балгадын суурь тавих, нохой худалдан авахад муу. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод зүүн хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал өлзийтэй сайн.

ӨДРИЙН ХҮН

# УЛАМЖЛАЛ ЭВДЭГЧ



Б.ПҮРЭВЖАВ

Нийслэлийн МАН-ын 34 дүгээр Бага хурал өнгөрөгч өдрүүдэд болж, удирдлагаа сонголоо. Тэд нийслэлийн МАН-ын хороог УУХҮ-ийн сайд Д.Сумъяабазарт даалгаж, өөрчлөлт шинэчлэлт, итгэл, найдварын хамт хүлээлгэж өгөв. Магадгүй энэ сонголт нь намдаа өөрчлөлтийг бас дэвшилтийг авчрахыг хүссэн олон залуусын мөрөөдөл биелэх шийдвэр болж чадсан гэхэд хилсдэхгүй болов уу. Нөгөөтэйгүүр, МАН-ынхан түүхэндээ байхгүйгээр нээлттэй, ардчилалтай, маргаантай, мэтгэлцээнтэй, шүүмжлэлтэй хурлаа хийж чадлаа. Үүний эцэст удтал хүлээлгэсэн нийслэлийн МАН-ын Бага хурлын гишүүд жирийн дэмжигчдийнхээ хүсэл, сонирхолд нийцсэн сонголтоо хийв. МАН-ынхан уламжлалт ёсоор нийслэлийн МАН-ын хороог хотын дарга С.Батболдод даалгахаар шийдвэрлэж, дэвшүүлсэн боловч заалнаас УУХҮ-ийн сайд Д.Сумъяабазар дэвшиж, олонхийн санал авсан нь ах намын хувьд уламжлал болон тогтсон бичигдээгүй “дэгт” цэг тавилаа. Нөхөд нь түүнд итгэл хүлээлгэсэн гол шалтгаан нь УУХҮ гэх Монголын эдийн засгийг түүчээлэх толгой яамыг хэрхэн удирдаж байгаа болон олон жил гацсан “Толгойн орд”-ыг хөдөлгөж, уул уурхайн салбарт шинэ дэвшил авчирч буйд найдсаных байх. Түүнчлэн намдаа зоригтой өөрчлөлт, шинэчлэлтийг эхлүүлж чадна гэж итгэсэндээ Д.Сумъяабазарыг дэмжсэн биз ээ.

Тиймээс нийслэлийн МАН-ын хороог ямар байлгах, хэрхэн удирдан чиглүүлэх, яаж өөрчлөх нь Д.Сумъяабазарын мэдэлд ирэв. Мөн МАН-д байгаа авлига, албан тушаалын наймаа, алдарт 60 тэрбумын асуудал гэх мэт болохгүй, бүтэхгүй бүхний төлөө сөрж зогсох ганц гарц түүнд үлдэв. Түүнийг нийслэлийн намыг хороог хэрхэн, яаж зөв зохион байгуулалттай удирдахаас МАН-ын 2020 оны хувь заяа шийдэгдэх юм.

SOCIAL MEDIA

**twitter**

Badrakh Naidalaa @Naidalaa
XX зуунд жолоочийг “шүтдэг” байв. Дараа нь цэргийн даргыг, Москвад төгсөгчийг, пүүсийн эзнийг, гадаадад сургууль төгссөнийг, Apple, Google-д ажилладгийг, Харвард төгсөгчдийг, дараа нь ... гээд хошуурч бн. Юм үзээгүй үндэстэн хорвоотой танилцаж буй нь энэ.Өөрийгөө олтол үргэлжилнэ

Boldsaikhan Bundan @Boldsaikhan_dr
сэтгэл програмчлагддаг ба сэтгэлчилэн биелдэг тул монголчууд: муу амлах, билэггүй яриа, уруу дорой бодох, толгой ганзгалж явах, өөрийн мэдэхгүй чадахгүй өөрт хамаагүй муу муухайд хутгалдахгүй байхыг захидаг байсан

Бямбаа @ByambaBob
Сүүлийн үеийн монгол кинонууд зүгээр ХОГ болчихож... Бүр бүх талаасаа ХОГ болж. Тэр зохиол, үйл явдал, дүрүүд, зураг авалт... Хамгийн гол нь дандаа цус, нөж, алаан, зодоон, хэрүүл, согтуу галзуу юмс. Аймшигтай нь бнга шаа, пиздаа, ална шүү, новшоо гэх мэт ХОГийн яриатай!!!

**facebook.**

Emi Egi
Тамхиа бариад урд алхахаа больчих тэгэх’үү. Нэг газраа зогсож байгаад татчих хэцүүн бэ. Эр, эм тамхичидаа

ӨӨР ӨНЦӨГ

# Ичдэггүй америкчууд

Х.БОЛОР

Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн Вашингтон хотноо хийж байгаа айлчлалын хамгийн их анхаарал татсан, гол ажил нь АНУ-ын Мянганы сорилын сангаас олгож байгаа 350 сая долларын буцалтгүй тусламжийн гэрээнд гарын үсэг зурсан явдал байлаа. Адуу 10 хүрвэл унах юм олддоггүй, хонь 20 хүрвэл идэх юм олддоггүй гэгчээр бөмбөрцгийн их гүрэн гэгдэх АНУ яачихсан хэмнэлт нь хэтэрсэн гэмээр орон бэ. Хоёр улсын найрамдалт харилцаа, хамтын ажиллагааны илэрхийлэл болох “том” гэрээг давчуухан өрөөнд даруухан гэгч нь үзэглэж байх юм. Манай Ерөнхий сайд, АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Майк Помпео хоёр шар давуугаар бүтээсэн жижигхэн ширээнд багталцаж ядан компакт гэрээнд гарын үсэг зурж, ёслов. Баавартай дарга нарынхаа нүнжигтэй ёслолд дассан бид үүнийг хараад гайхаж хоцорлоо. Бүр үүгээрээ Монгол Улсыг дорд үзлээ хэмээн ундуucах хүмүүс ч байна. Дэлхийд тэргүүлэх баян, тансаг орон атал манай улсын сургуулийн захирлын өрөөний энд ч хүрэхээргүй танхимтай байх гэж. Өөрийгөө биш юм гэхэд улсынхаа нэрийг боддоггүй юм байх даа. Манайхан ядуу ч гэлээ хэдэн дарга нар маань харин хаана ч дээгүүр зиндаанаас мултрахгүй шүү. 1.5 тэрбумаар орон сууц, 200 сая төгрөгөөр LEXUS 570 авч унах бол манай дарга нарын энгийн хэрэглээ. Ажлын өрөө гэдэг даргын өөрийгөө хүндлэх байдал, нэр төрийн илэрхийлэл, нэг ёсны удирдах ажилтны нэрийн хуудас гэж манайхан ойлгодог. Тийм ч учраас дарга солигдоход өрөө ч бүрэн шинэчлэгддэг албан бус уламжлалтай. Хуучин даргын эдэлж, хэрэглэж байсан зүйлс хэчнээн үнэтэй, ямар ч зүйл байсан хамаагүй бүгд браклагдаж, өрөөний шинэ эзэн өөрийнхөө хүсэлд нийцүүлэн цоо шинээр хамгийн тансаг, тохилог байдлаар өөрчилдөг. Манайх ядуу орон ч гэлээ дарга нар маань харин дэлхийн энтэй баян сэтгэлгээтэй, тансаг хэрэглээтэй, хаана ч явсан бидний нүүрийг улалзуулахгүй улс юм шүү. Гэтэл дэлхийд тэргүүлэх баян улс атал хуучин хивстэй, муухай өрөөтэй америкчууд ичиг ичиг. Манай улсын сумын сургуулийн захирал ч ийм энгийн жижигхэн ширээ тоож хэрэглэхгүй. АНУ-ын иргэд баян, бид ядуу байж болох ч дарга нарынхаа хэрэглээгээр бол манайх АНУ-ыг хавьтуулахгүй шүү.

Books “Ном” буланд тавтай морил

## Ñ¯Í ÓËÑÛÍ Õ¯ÉÒÝÍ ÓÓËÛÍ ÁÈ×ÈÃ

**Түрүүч нь №160 (5010)**
**Үргэлжлэл.**

Үүнд Ши Жинь нарын дөрвөн жанжин Ман Даншанийн уулын Сян Чүн, Ли Гүнь хоёр лугаа байлдаж цэрэг морио бага алагдсан учрыг өгүүлсэнд, Хуа Рүн өгүүлрүүн: “Манай Лян Шань уулны Сүн Гүнмин энэ учрыг мэдээд та дөрвийг гэнэдэх болууужин хэмээн бид хоёрыг тусуулуахаар илгээв.”хэмээсэнд Ши Жинь маш баярлан бүгд цэргээ нэгэн хамт болгож, цэргийн хүрээлэн байгуулж, тэндээсээ нэгэн их цэрэг морины тоос хөдлөн гарч ирсэнд Хуа Рүн, Сюй Нин, Ши Жинь, Яньчүн, Чэнь Да, Жу Ү нараа ширвээтэж сэтгэл зовон бүхүй тэрхүү цэргийн тоос нь ойртож байхыг үзвээс Сүн Гүнмин өөрөө Ү Шюэжү, Гүн Сүншэнь нарыг дагуулан олон цэргийн хамт өөрийн цэргийн жагсаал дээр ирсэнд, тэд нар цөм угтаж цацартаа оруулж, Ман Даншаний Сян Чүн, Ли Гүнь хоёрт дарагдсан нарийн учрыг Сүн Жян нарт хэлсэнд Ү Шюэжү өгүүлрүүн: “Эд нэр тийм амар байлдаж болохгүй.Цэрэг морио сайнаар харгалзаж, арга зөвлөн байлдваас сайн.” хэмээв.Тэр өдөр нар орой болж, тэр уулын орой дээр олон хөх өнгийн дэнлүү шатааж баймуй.Үүнд Гүн Сүньшэн үзээд маш цочиж, тэдгээр Сүн Жян нарт хэлээд, ийн өгүүлрүүн: “Эдүгээ энэ дэнлүүний өнгийг үзвээс эд нар сурсан увдис маш олон. Түүнийг хариулах арга үл хийх аваас хэрхэвч болохгүй. Тиймийн тул олон муу сангарсва. Би урьд Лао Жэньрэнь багшийн зааж хайрласан аргыг энэ шөнө бүтээж хоноод маргааш жич хэлэлцэе хэмээв. Энэ нь Хунши Муван хэмээх их төрийг самууруулагч Фань Руй алгаа хамтатгаж Лян Шань Фү ууланд урвах. Бурханы цэрэг туслан ирж урвасан Сян Чүн, Ли Гүнь нарыг эрхээр дагуулах хэмээжүхүй. Үүнд Гүн Сүньшэн хэмээх сангарсва ямар арга хэрэглэж, яахин байлдахыг хойд бүлэгт үзэгтүн.

### ТАВИН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

*Гүн Сүньшэн Ман Даншань хэмээх ууланд увдисаар бугийг дарж оргуулан авах.*
*Чао Тяньван хэмээх Чаогай Зэн Тоуши хэмээх газар суманд харвагдаж шархлох.*

Өгүүлэх нь, тэндээс Гүн Сүньшэн нарийн увдис хэрэглэж Ман Даншань уулын Фань Руй, Сян Чүн, Ли Гүнь нарыг ямар увдисаар, хэрхэн хэрэглэж авахыг Ү Юн, Сүн Жян нар асуусанд Гүн Сүньшэн өгүүлрүүн:”Би санаваас миний энэ бодлого маш бэрх хэцүү. Хан улсын төрд байсан Гүньминь хэмээх өргөлгөөс? маш хэцүү илүү бодлого, дөрвөн зүг найман зовхист олон цэргийн жагсаал байгуулж уулыг бүрхүүлэхээс гадна, түүний төв дунд нэгэн их сайд суулгая. Түүнийг хүн үзвээс дөрвөн толгойтой, найман сүүлтэй, буруу эргэх зөв эргэх, тэнгэр газраас салхи дэгдэх луу ба барс могой араатны хүчтэй маш их хэцүү арга. Энэ уулын урвасан Фань Руй нарын гурван хулгай уулаас бууж ирэх цагт, хоёр талаар хоёр урт могойн жагсаал жагсая. Түүний гадна энэ гурав могойн цэргийн жагсаалд орвоос мэдээг хүргэх долоон одны цагаан өнгийн дарцаг байгуулж тавья. Түүний хөдөлсөн цагт би увдис уншин, тарни гаргаж арга бүтээе. Тэр гурав энэ жагсаалд орж ирвээс, хойш урагш хаашаа ч хөдөлж чадахгүй, дээр орлого мөнгө эеврэх. Зогсолт ийм дөрвөн зүгт нарийн аргыг бас үйлдвээс сайн. Энэ арга юу хэмээвээс тэр зүгт нэгэн их нүх ухмуй. Түүний дээр чийрс модоор бүтээж тагламуй. Эдгээр гурав хэдэн жагсаалаас мултран гарч зугтах зүг нь тэр. Тиймийн тул та нар тэр нүхэнд эрхгүй орж баригдах тэр цагт, хэдэн зүгээс чадалтай сайн цэргийг гаргаж, тус тус төмөр дэгээ барин бүгшүүлж байгаад тэдний тэр нүхэнд орсны хойно, дэгээгээр дэгээдэн авч баримуй.” хэмээсэнд Сүн Жян олон цэрэг жанжин цэрэгтээ эдгээр үгийг цөм тушаагаад анги ангиар сэмхэнээр үйлдэгтүн. Өчүүхэн төдий гажуудваас цааз алдах хэрэг тогтмуй.”хэмээсэнд тэдгээр цөм тус тусын тушаалыг дагав. Үүний дотроос энэ хэрэгт оногдсон жанжин Хү Яньжуо, Жү Түн, Хуа Рүн, Сюй Нин, Мурун, Сюньли, Ши Жинь. Дунд тоонд Люйфан, Чай Жинь, Гуо Шэн нар. Дунд тугийг сайн эрээр захирч байгтун. Сүн Жян, Ү Юн, Гүн Сүньшэн, Чэнь Да нарын дунд тоонд хавсран баймуй. Жу Ү хэдэн гавшгай цэрэг авч нууцаар Ман Даншань уулын цэргийн жагсаалыг хаана хэрхэн байгуулах, аль замаар ирэх зэргийг өдөр шөнөгүй ойр уулын орой дээгүүр сайнаар ажиглан байгтун.”хэмээн тушаасанд хойно маргааш өдөр могой цагт, тооны ёсоор энэ хэргийг бүтээгээд Ман Даншань уулын бэлд олон жанжин цэргээ авч өдөөн ирэв.

Тэндээс Ман Даншань уулын харуулын цэрэг Ляншаний цэрэг хэнгэрэг харанга зэргийг сонсоод даруй ууланд очиж Фань Руй нарын гурван даргад энэ учрыг хэлсэнд, тэдгээр гурван дарга бүрмөсөн хуяг дуулгаа өмсөөд хэнгэрэг харангаа дэлдэн, гурван мянган цэргээ бүгд дагуулан цэрэглэн ирж жагсав. Зүүн талд Сян Чүн, баруун талд Ли Гүнь, дунд их дарга Фань Руй. Үүнд цөм зэргээр жагсаж, их жагсаал тогтов. Тэндээс энэ Фань Руй хэдий увдистай боловч цэргийн нарын жагсаалыг олж мэдэхгүй Сүн Жяний цэргийг дөрвөн зүг харж үзвээс бүгд цэрэг тал талд жагсаасан нь мод шугуй мэт. Үүнийг Фань Руй үзээд маш баярлан, ийн сэтгэрүүн: “Ляншаний урвасан хулгайн цэргийг үзвээс эдүгээ миний эрхэнд орох цаг болжухуй”хэмээн бодож байтал, аль нь ч хөдлөхгүйд Хунши Му Фань хэмээгч төрийг самууруулагч Фань Руй, Сян Чүн, Ли Гүнь хоёрт ийн захив. “Эдүгээ энд хүлээх юү. Гагцхүү миний увдисыг сайтар мэдэж байгтун. Хэзээ салхи тогтвоос Сүн Жяний цэргийн жагсаалд орогтун. Олон нисэх сэлмийн тигэвшийг? нисгэгтүн.”хэмээн захиад, даруй тарни уншин салхи дэгдээв.

Тэндээс тэнгэрийн нар халхлагдаж харанхуй болсонд, Сян Чүн, Ли Гүнь хоёр таван зуун сэлэм барьсан цэргээ авч Сүн Жяний цэргийн жагсаалыг дайран алалцахаар ирэв. Үүнд Сүн Жян шидээр байгуулсан хоёр урт могойн жагсаалын тарнийг уншиж, долоон цагаан могой одны дарцгийг хөдөлгөсөнд нар зөв, нар буруу аль нь ч мэдэгдэхгүй. Хөөрхий хоёр жанжин Сян Чүн, Ли Гүнь зам эрж зугтан гарахыг бодовч яахин зам олдмуй. Үүнд арга барагдаж байтал Жү Гүйгийн харуулд нэгэн шидэт улаан дарцаг буй. Тэр дарцгийн доор Гүн Сүньшэн довтлон очиж тарни уншин байсанд, тэдний увдист салхи хураагдаж Сян Чүн, Ли Гүнь хоёрын морины бөгс сүүлээс холдохгүй, тэр хоёрын бие морины хамт эргэхээс өөр ер явахгүй. Мөн дөрвөн зүг басхүү харагдахгүй. Дээр тэнгэр мөн үзэгдэхгүй, хоосон нэгэн уур манан дотор яваа мэт баймуй. Үүнд тэр хоёр жанжин хэрхэх ч аргагүй салхинд эрхшээсэн явтал харин нэг их нүхэнд унав. Энэ нь Гүн Сүньшэнгийн жагсаалын шид тул Фань Руйн салхины арга яахин болмуй. Иймийн тул Фань Руй үүнийг үзээд маш айж байтал, дараа тэр Сян Чүн, Ли Гүнь хоёрыг нүхний дэргэд бүгшсэн цэрэг гарч төмөр дэгээгээр дэгээдэн гаргаж барьж хүлээд Сүн Гүнмин нарын дэргэд хүргэн ирэв. Үүнд Сүн Жян үлдсэн тэднийг цэрэг ба Фань Руй нарыг барих хэмээн морин ташуурыг гурвантаа дохисонд гурван хэсэг жагссан цэрэг цөм Фань Руй нарыг хөөж алалцахаар орсонд Фань Руй даруй өөрийн хэдэн цэргээ авч Ман Даншань уулнаа буруулан зугтав. Үүнд Фань Руй өөрийн цэргээ тоолж үзвээс их төлөв жагсаалд үхжүхүй.

Тэндээс Сүн Жян өөрийн цэргээ хураан аваад дунд жагсаалд очиж цацарт суусан хойно барьсан хоёр жанжин Сян Чүн, Ли Гүнь хоёрыг хүргэн ирсэнд Сүн Жян өөрийн биеэр тосож аваад цацарт оруулан, тэдний хүлээсийг тайлж, ийн өгүүлрүүн: “Мэргэн жанжин бидэнд гомдох хэрэггүй. Цэрэг дайны ёс ийм эс болно. Яахин байлдах буюу. Өчүүхэн хүний санасан нь мэргэн гурван жанжныг оруулан аваад Лян Шань ууланд залж аваачаад, ах дүү болъё хэмээсэн нь эртний бодлого тул эдүгээ ирж байлдав” хэмээн архи барьсанд Сян Чүн, Ли Гүнь хоёр ёслон сөгдөж ийн өгүүлрүүн: “Мунхаг дүү нар энэ хэргийг хэдүйнээ санасан боловч, хувьгүй болоод, эдүгээ Фань Руй лугаа энэ Ман Даншаньд урваж суув. Эдүгээ нэгэнт эрхэм жанжин таны гарт баригдсан тул гуйх нь: хишиг хүртээж бид хоёрыг үл голох болбоос таалалдаа агуулж, уулandaa аваачиж асрахыг гуймуй.”хэмээн мөргөсөнд Сүн Жян өгүүлрүүн: “Мунхаг ах нь эртнээс эдүгээ хүртэл сайн эрсийг журмаар дагуулан тэтгэсэн нь гагцхүү тэнгэрийн журмыг дагаж энэ мэт хэрэг үйлдмүй. Харин хоёр дүү үл ойшоох ахул, мунхаг ахын гуйсныг оюундаа тогтоон соёрхох болов уу.”хэмээн өгүүлсэнд, тэр хоёр бас ийн өгүүлрүүн: “Мунхаг дүү нар эдүгээ Сүн Гүнмин ахын тааллыг яахин гажуудуулж болмуй. Тиймийн тул Фань Руй хэмээгч ертөнцийг сарниулагч жанжин бид хоёр үгүй бөгөөс тэр яахин энэ уулыг эзлэн суумуй. Тиймийн тул түүнийг бид хоёрын нэгийг илгээж, түүн лугаа учруулан эл бүхнийг хэлвээс, тэр Фань Руй үл дагаж ирэх ёс үгүй. Ийм учирт өршөөвөөс, бид хоёрын нэгийг илгээж Ман Даншань ууланд илгээх ажаамуу.”хэмээсэнд Сүн Жян өгүүлрүүн: “Мэргэн хоёр дүүгийн хэлэх нь маш зөв. Тэр хэрвээ эс дагаж ирэх болбоос түүнийг хүчээр барьж авах нь үлгэрлэвээс, тэнгэр дэлхий хоёрыг хамааруулах ба аргын шимийг тавьж, аюулт тамд унагаж барих лугаа адил тул, эрхэм мэргэн дүү нар очиж урьдаар учрыг нь ухуулан хэлэгтүн.”хэмээсэнд, тэр хоёрт шинэ хувцас сольж өмсгөөд архи барьж, өөр өөрийн барьж явсан тинбэй? сэлэм жадыг эгүүлэн тушаав. Хойш буцаахаар завдсанд Ү Шюэжү ийн өгүүлрүүн: “Урьд адил үл дагах бөгөөд бас байлдах хэмээвээс бүү түүнийг албадан дагуулагтун. Түүний гадна та хоёр бас хуучин хэвээр тэнд очоод урвах болбоос, эдүгээ хожим гомдох газаргүйг урьдаас ухуулан хэлсүгэй.”хэмээсэнд, тэр Сян Чүн, Ли Гүнь хоёр ийн өгүүлрүүн: “Урьдын хийсэн буруу ялыг нэгэнт уучилж, амь аварсан нь тэнгэрээс хишиг буусан адил тул, бид хоёр яахин тийм зүй бус хэрэг хиймүй. Эрхгүй Фань Руйг бариад хүргэж ирвээс барав.”хэмээсэнд тэр хоёр жанжны үг хэлийг авч цэргийн жагсаалаас дахин давтан засаж, Ман Даншань ууланд хэдэн зуун цэрэг дагуулан илгээв. Үүнд тэр хоёр явж, даруй Ман Даншань ууланд хүрч одоод, Фань Руйд сөгдөж ийн өгүүлрүүн: “Мунхаг дүү нар нь Ляншаний цэргийн жагсаалын овлолд автагдаж, аргагүй нүхэнд орж баригдаад хүлэгдэн, Сүн Гүнмин хэмээх Сүн Жян д учрав. Тэр нь үзвээс үнэхээр тэнгэрийн журам дагасан, дөрвөн этгээдэд гайхамшигтай явдал дэлгэрсэн хүн бөгөөд бас амандаа үг өгүүлэх нь үнэхээр маш мэргэний дээр сайн эрсийг авах, муу залихайг арилгах тийм хүмүүн гэнэм. Иймийн тул, бид хоёр маш баярлан энэ Сүн Гүнминг дагаж ороод, Лян Шань ууланд очиж журмын ах дүү бололцоё хэмээн ам нэгэнт авч, тангараг тавив. Үүнд Сүн Гүнмингийн захисан нь:”Фань Руй ах чамайг зүйтэй болбоос журмыг дагаж тэнгэрт мөргөмүй. Зүйгүй болбоос Ман Даншань уулыг морин цэргийн тоосоор дарагдаад, эцэст хөлөөр өшиглүүлж түвшин болгомуй. Түүний гадна Фань Руйг их цэргийн жагсаалд оруулж, арга билгийн гал шатааж үнсэн товрог болгож, эд мөнгө юмыг бүрнээ хураан авч, Лян Шань уулandaa аваачмуй. гэх зэрэг үг хэлэв.” хэмээсэнд Фань Руй маш айж, ийн өгүүлрүүн: “Та хоёр дүү нэгэнт дагасан тул, би гагцаар яахин үлдэж болох буюу. Тиймийн тул та хоёр ирж энэ учрыг хэлсэн нь маш сайн. Бид маргааш өглөө эрт босоод очиж, Сүн Гүнминд дагаж ороод, Лян Шаньд очсугай.”хэмээн маргааш нь эрт босоод Ман Даншань уулнаас цэргээ орхиж буун ирээд, Сүн Жяний байгуулсан дунд тугт ирж Сян Чүн, Ли Гүнь хоёр урд орж,Сүн Гүнминд Фань Руйг дагуулан ирсэн явдлыг сонсгосонд Сүн Жян маш баярлан, даруй угтан гарч Фань Руйд амар эрсэнд, Фань Руй сөгдөн мөргөсөнд, Сүн Жян дээш босгож, цацартаа оруулж, бүгдээр дагаж ирсэн их баярын архи барьсанд, тэр гурав урьдын хүн алсан ба юм дээрэмдсэн учраа нэг нэгээр хэлэхэд, Сүн Жян өгүүлрүүн: “Энэ нь ертөнцөд төрсөн хүний сайн муу, гараг жил тохиолдож, эцэг эхээс төрсөн учир түүний гадна басхүү ямар учирт тийнхүү явахыг тэнгэр заяасан номлол буй тул түүнд зовох юун. Мэргэн дүү нар харин цэргээ үл авчрах нь жигтэй.”хэмээсэнд Фань Руй өгүүлрүүн: “Мунхаг дүүгийн ууланд алтан тавaар, алт мөнгө, цэргийн зэвсэг, морь тэргүүтэн мөн ч нэлээд их юм буй тул, түүнийг дахин очиж авмуй. Олдвоос, мэргэн ах тэргүүлэн, олон жанжин цэрэгтэйгээ үл голох аваас, миний өчүүхэн ууланд очиж, нэгэн цагийн архи ууж, ногоо будаа зоогловоос ямар?” хэмээн гуйсанд Сүн Жян Гүн Сүньшэн, Ү Шюэжү хоёрт энэ үгийг сэмхэн хэлсэнд, тэр хоёр хариу өгүүлрүүн: “Үүнд Ман Даншань ууланд одоо эднийг дагаж очиход гэмгүй.”хэмээсэнд Сүн Жян даруй Фань Руйн гуйсан ёсоор болж, олон жанжин цэргээ харанга хэнгэрэг дэлдэн жагсааж, Ман Даншань ууланд гарч ирэв. Үүнд Фань Руй даруй Сүн Жяний гараас барьж, их байшиндаа оруулж, олон жанжныг цөм урьж Сүн Жянийг дараалан суулгаж цай бариад, үхэр хонь алж хурим бэлтгэв.

**Үргэлжлэл дараагийн дугаарт**